

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023.07.05

Говьсүмбэр

НЭГ: УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

**Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын болон захиргааны
баримт бичгийн хэрэгжилтийн талаар**

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 01 сарын 25-ны өдрийн А/27 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт батлах” тухай тушаалын хэрэгжилтийг хангах чиглэлээр 59 баримт бичгийн хүрээнд 104, нэмэлтээр 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн мөн Захиргааны удирдлагын газрын даргын 5а/4548 албан бичгийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд агентлаг, байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хийсэн үнэлгээнээс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх 5 заалт бүхий төлөвлөгөө, 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар батлагдсан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн зорилт, шалгуур үзүүлэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус батлуулан зүйл заалтыг тусгасан төлөвлөгөө гарган хариуцах албан тушаалтнуудад хуваарилан баталгаажуулж биелэлт үр дүнг улиралаар тооцон ажилласан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/, аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас гаргасан албан даалгавар, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан.

**Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал,
тушаалын тоо**

Цагдаагийн хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар 2023 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг жилээр гарган, төлөвлөгөөний дагуу даргын зөвлөлийн хуралдааныг 6 удаа 38 асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлэн зөвлөлийн хурлын мэдээллийг нэгтгэн тухай бүр алба хаагч нарт танилцуулан ажиллав. Мөн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх санал, материалыг нэгжийн дарга нараас сар бүр авч нэгтгэн төлөвлөгөөнд тусган хэвшүүлсэн.

Цагдаагийн хэлтсийн даргын тушаал 126 гарснаас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр (“А” тушаал 37), хүний нөөцийн чиглэлээр (“Б” тушаал 89) гарган хэрэгжүүлж ажиллав.

Хүний нөөцийн бодлогын талаар

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/135 дугаартай тушаалаар цагдаагийн хэлтсийн бүтэц, орон тоог Захиргааны удирдлагын тасаг, Эрүүгийн цагдаагийн тасаг, Мөрдөн байцаах тасаг, Хэрэг бүртгэх тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Замын цагдаагийн тасаг, Шивээговь сумын цагдаагийн хэсэг, сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа гэсэн бүтцэд оруулж 81 орон тоотойгоор шинэчлэн баталсан.

2020 онд бүтэц дотор шинээр Эрүүгийн цагдаагийн тасагт Экологийн асуудал хариуцсан ахлах мөрдөгч 1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/313 дугаар тушаалаар Замын цагдаагийн зохицуулагч 1, мөн оны А/316

дугаар тушаалаар Хүүхдийн асуудал хариуцсан ахлах байцаагч 1, А/319 дугаар тушаалаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагч 1, А/06 дугаар тушаалаар сэтгэл зүйч 1, А/318 дугаар тушаалаар Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажил хариуцсан ахлах байцаагч 1 орон тоо батлагдаж нийт 87 орон тоотойгоор үндсэн үүргээ гүйцэтгэн ажиллаж байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга 1, Шуурхай удирдлагын тасгийн дарга 1, эрүүлжүүлэх саатуулах байрны эмчийн 1, эрүүгийн мөрдөгч 1, Замын цагдаагийн тасгийн цагдаа зохицуулагч 3, эргүүлийн цагдаа 1, холбоо мэдээллийн инженер 1, нийт 9 орон тоо дутуу, нийт 73 алба хаагч, 5 энгийн ажилтан ажил үүрэг гүйцэтгэв.

Цагдаагийн хэлтэст сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор 3 удаагийн сургалтад иргэдийг сонгон шалгаруулах зарыг хэлтсийн цахим хуудас, мэдээллийн самбар, орон нутгийн хэвлэл, мэдээ мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор 12 удаа иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулав.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-901/-д заасан сул орон тоонд тавигдах болзол шаардлага хангасан 6 иргэний материал, холбогдох судалгааг хийж, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шаардлага хангасан 6 иргэний санал, материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн Төрийн албаны салбар зөвлөлийн сонгон шалгаруулалтад хамруулан 3 иргэнийг сул орон тоонд томилуулан ажиллав. Мөн Дотоод хэргийн их сургуулийн ахлагчийн сургуульд 2 иргэн хамрагдаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Албан тушаал дэвшүүлэх /код-909/-ын дагуу болзол шаардлага хангасан, хүний нөөцийн судалгаа, алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ, ажлын үзүүлэлт, төрийн албаны мерит зарчмыг баримтлан даргын зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэж 5 иргэнийг ахлагчаар, 4 ахлагчийг офицероор, 4 офицерыг ахлах (1), чиглэлийн ахлах 1, тасгийн даргаар 2, хэлтсийн даргын нөөцөд 2 нийт 17 алба хаагчийг тус тус цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгүүлэх саналыг хүргүүлэн шалгалтад тэнцсэн 5 иргэнийг ахлагчаар, 4 ахлагчийг офицероор, 3 офицерыг ахлах, чиглэлийн ахлах 1, тасгийн даргаар 2 тус тус алба хаагчдыг албан тушаал дэвшүүлэн шийдвэрлүүлсэн.

Нийт алба хаагчдаас эрэгтэй офицер 40, эмэгтэй офицер 7, эрэгтэй ахлагч 36, эмэгтэй ахлагч 1 ажиллаж байгаа ба тэдгээрийн 68,6 хувь нь дээд боловсролтой, 20 хувь нь бүрэн дунд, 11,4 хувь нь тусгай дунд боловсролтой байна. Алба хаагчдын 43,5 хувь нь офицер, 50,4 хувь нь ахлагч, 6,1 хувь нь энгийн алба хаагчид байна. Алба хаагчдыг насны байдлаар авч үзвэл 65,8 хувь нь 35 хүртэлх насны залуучууд байна.

Тайлангийн хугацаанд чөлөө, зөвшөөрөл авсан 13 алба хаагч байгаагаас хэлтсийн даргын тушаалаар цалинтай 2, ээлжийн амралтаас 6 алба хаагч чөлөө авсан.

Шинээр томилогдсон 14 алба хаагчдыг албанд сургаж, дадлагажуулах халамжлан хүмүүжүүлэгч багшийг цагдаагийн хэлтсийн даргын тушаалаар томилон дасан зохицох хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулуулан танилцуулгыг даргын зөвлөлийн хурлаар 1 удаа хэлэлцүүлж, үр дүнг тооцож ажиллав.

Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсээс ирүүлсэн хамтын ажиллагаатай Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харъяа академи, их, дээд сургууль, Дотоодын хэргийн их сургуулийн эчнээ, бакалавр, энгийн дээд сургуулийн сургалтын талаарх албан бичгийг алба хаагчдад танилцуулан ажиллаж, Цагдаагийн хэлтсийн 2 алба хаагч Дотоод хэргийн их сургуулийн магистр, Хууль зүйн “Орхон” их сургуультай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд магистрын сургалтад 8, баклаварын сургалтад 8 алба хаагчийг тус тус суралцах боломж нөхцөлөөр ханган Дотоод

хэргийн их сургуулийн магистрыг 1 алба хаагч, Орхон их сургуулийн магисрыг 8 алба хаагч төгсөж диплом, энгэрийн тэмдэг гардан авсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар тасгийн дарга 2, чиглэлийн ахлах мэргэжилтэн 1, ахлах 3, офицерын албан тушаалд 2, албан тушаал өөрчилсөн 1, шилжиж ирсэн 2, явсан 4 (офицер 2, ахлагч 2), цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 2, хүний нөөцийн хэлтсийн зөвшөөрөлөөр цагдаагийн дэд ахлагч 4, албанаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 3 (офицер 2, ахлагч 1) тус тус санал, материалыг хүргүүлэн шийдвэрлүүлсэн байна.

Алба хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор анх ажилд орсон, дэвшин томилогдсон, шилжин ирсэн алба хаагч нартай хамтарсан гэрээ байгуулан, тасаг, хэсгийн дарга нар дагалдах хуудсаар зааварчилга, зөвлөмж өгч, сар бүр дүнг тооцож хэвшүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан “Ёс зүйн” төлбөртэй сургалтад 3, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй харилцах хэлмэрч, хөтөч цагдаагийн сургалтад 1, зохицуулагч нарын сургалтанд 1, шинэ зөрчлийн сан ашиглах мэргэшүүлэх сургалтад 1 нийт 6 алба хаагчийг хамруулав.

Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн энэ оны 4 дүгээр сард Улаанбаатар хотод 2 өдөр томилолтоор ажиллаж цагдаагийн хэлтэст нэн шаардлагатай байгаа сэтгэл зүйч, эрүүлжүүлэх саатуулах байрны эмч, холбооны инженерийн хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр “Шинэ ангаах ухааны их сургууль”, “Хүмүүнлэгийн их сургууль”, “Техникийн их сургууль”, “Их засаг их сургууль”, “Билиг их сургууль”, “Нийгмийн сэтгэл зүйн их сургууль” зэрэг 8-н сургуулийн төгсөх курсын 377 оюутнуудтай уулзалт зохион байгуулж цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үнэ цэнэ, цагдаагийн байгууллагад ажиллахын ач холбогдлын талаар мэдээлэл хийж ажилласны үр дүнд эрүүлжүүлэх саатуулах байрны эмчээр ажиллах хүсэлт гаргасан 4 иргэнд хүний нөөцийн судалгаа хийж 1 иргэний материалыг шийдвэрлүүлэхээр санал хүргүүлээд байна.

Алба хаагчдын дунд зохион байгуулсан албаны сургалт, түүний үр дүнгийн талаар

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/46 дугаар тушаалаар 2023 оны “Албаны болон давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Албаны сургалтын төлөвлөгөө”-г хоёрдугаар, “Алба хаагчийн үргэлжилсэн сургалтын төлөвлөгөө”-г гуравдугаар, “Давтан, мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө”-г дөрөвдүгээр хавсралтаар баталсантай уялдуулан байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн цагдаагийн хэлтсээс 2023 онд зохион байгуулах албаны сургалтын хөтөлбөрийн хүрээнд салбар төлөвлөгөөг гарган хуваарийн дагуу албаны сургалтыг зохион байгуулан ажиллав.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар 35 удаагийн 69 цагийн сургалтыг батлагдсан хуваарь, удирдамжийн дагуу зохион байгуулж, давхардсан тоогоор 2444 алба хаагчийг хамрууллаа.

Алба хаагчийн мэдвэл зохих хууль тогтоомжоор 9 удаа 16 цаг, хөгжүүлэх чиглэлээр 16 удаагийн 24 цаг, дадлагжуулах 3 удаа 11 цаг, бие бялдарын бэлтгэлжилтийг хангах чиглэлээр 3 удаагийн 193 цаг, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарсан 2 удаагийн 5 цагийн багтаамжтай сургалтыг тус тус зохион байгуулав.

Мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтыг 9 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 630 алба хаагч хамрагдсан. “Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа явуулах үндэслэл”, “Цагдаагийн албаны тухай хуулийн 1, 2 дугаар бүлэг”, “Дотоодын цэргийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль”, “Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт”, “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт

тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 100 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний асуудал төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам”, Засгийн газрын 2023 оны 120 дугаар тогтоол “Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”, Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2023 оны А/12 “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 122, 136, 137, 721, 924-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2023 оны А/63 “Олон нийтийн цагдаагийн дүрэм, түүнд тавигдах шаардлага, гэрээний загвар”-т нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2023 оны А/116 “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 123, 124-д нэмэлтт өөрчлөлт оруулах загвар батлах тухай”, Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2023 оны А/ 71 “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 112, 511, 925-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2023 оны А/ 58 “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 809, 817, 917-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай” сэдвээр алба хаагчдад мэдээлэл хийж сургалт зохион байгуулсан байна

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, “Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”, “Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль”, “Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны А/45 дугаар тушаал “Гадаадын их дээд сургуульд хууль сахиулах байгууллагын алба хаагчийг сонгон шалгаруулах, суралцуулах журам”-ын төсөл, Хууль зүй дотоод хэргийн яамны 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 2/2367 дугаар “Шинжилгээ хийх жишиг хугацаа батлах тухай тушаалын төсөл”, Монгол улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлт, Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2017 оны А/265 тушаалаар батлагдсан “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох /код 515/ журам”-ын төслийг алба хаагчдад судлуулж 7 удаагийн хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 315 алба хаагч хамрагдсан.

Алба хаагчийг хөгжүүлэх сургалтыг 16 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 225 алба хаагч хамрагдсан. Үүнд: “Баатарлаг туульс”, “Гав хэрэглэх үндэслэл журам”, Авилгын тухай ойлголт, авилгаас урьдчилан сэргийлэх нь”, Тактикийн таних тэмдэг”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт”, сэдвүүдээр тус тус 1 удаагийн сургалтыг зохион байгуулсан.Сургагч багш нараар давхардсан тоогоор 13 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 822 алба хаагчийг хамруулсан бөгөөд албан тушаал дэвшүүлэн томилуулах болзол шалгуур хангасан 8 алба хаагчийг Цагдаагийн ерөнхий газрын албан тушаал дэвшүүлэх нөөцийн сургалтад хамруулж томилуулав.

Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарсан сургалтыг 17 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 765 алба хаагч хамрагдсан.Үүнд:

Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Удирдлагын академиас зохион байгуулсан “Алсын хараа 2050”, “Аймгийн төрийн байгууллагуудын хэвлэл, мэдээллийн ажилтнуудын сургалт”, Сүмбэр сумын ЗДТГ-аас зохион байгуулсан “Хувь хүний хөгжил, эерэг хандлагыг төлөвшүүлэх” сургагч багш бэлтгэх сургалт, аймгийн Насан туршийн боловсролын байгууллагын “Жендерийн тэгш байдал”, “Гоо зүй”, И-Монгол академи, УТҮГазартай хамтарсан “Цахим засаглал”, “Тоон гарын үсэг”, аймгийн Нийтийн номын сангийн “Ном уншихын ач тус, аймгийн Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах батлуулах, тайлагнах үр дүнг үнэлэхэд анхаарах асуудал”, хувь хүний соёл, харилцаа хандлага, ёс зүйн чиглэлээр “Олон улсын сэтгэлийн боловсрол төв”-ийн сэтгэл зүйч, багш лектор Солонгос улсын иргэн Бэ Дун Сик, Ким Ду Ён нарыг урьж “Таны хэлснээр амьдрал бүтээгдэнэ”, Мөн “Иргэдийн эрүүл мэндийн хөгжлийн төв”-ийн сургагч багш Б.Даваажаргал “Эрүүл зөв амьдралын хэв маяг”, Сүмбэр сумын 5-р сургуулийн сэтгэл зүйч Н.Хандсүрэн “Байгууллагын соёл, сэтгэл зүй”, аймгийн Гэр бүл залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн Э.Магвансүрэнг урьж “Байгууллагын соёл алба хаагчийн харилцаа хандлага”, “Нарны алтан оньс төрийн бус байгууллагын илтгэгч соён

гэгээрүүлэгч Н.Нансалмаа, Б. Мөнхцэцэг нарыг урьж “Хувь хүний сэтгэлийн амар амгалан байхын ач тус”, Төрийн банкны мэргэжилтэн н.Батжаргалыг урьж “ Хувь хүний санхүүгийн боловсрол”, Эрүүл амьдралын жигүүр төрийн бус байгууллагын эмч Б.Мөнх-Эрдэнэ” Эрүүл мэндийн боловсрол”, XS спенинг бялдаржуулах төвийн багш Б.Хишигсүрэн”Эрүүл зөв амьдралын хэв маяг” сэдвүүдээр тус тус 1 удаагийн сургалт зохион байгуулсан.

Мөн дээрх сургалтуудаас гадна Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны 2023 оны сургалт зөвлөгөөнд алба, нэгж болон хамтын ажиллагаатай бусад төрийн байгууллагаас хийсэн мэдээлэл, илтгэлүүд, Монгол улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэний “Шинэ сэргэлтийн бодлого”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт” сэдэвт сургалтанд хэлтсийн нийт алба хаагчид цахимаар бүрэн хамрагдсан.

Цагдаагийн ерөнхий газар болон харъяа албад, цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулагдсан сургалтуудад 2, Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсээс 2023 оны 01 дүгээр сарын 06-ний өдөр зохион байгуулсан Go Smart ХХК-ний цахим сургалтын цогц платформийг ашиглах, сургалтын модулийг системд оруулах цахим сургалтанд 1 алба хаагч хамрагдсан.

Системийн динамик загвар”-ыг /Т-21/, “ARCGIS” программ хангамжийг нэвтрүүлэх цахим сургалтанд хэлтсийн дүн шинжилгээ судалгааны багийн 3 алба хаагч хамрагдсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 180 дугаар зарлигаар баталсан “Цэргийн нийтлэг дүрэм шинэчлэн батлах тухай”, цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хэрэглэгдэх “Тактикийн таних тэмдэг, тэмдэглэгээ”, Дотоодын цэргийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн албан хаагчийн биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах журам”-ын хэрэгжилт, алба хаагчдын албаны бэлтгэлжилтийг хангах галт зэвсэг хэрэглэх, буудлагын дадлага сургалт зохион байгуулах тухай цагдаагийн хэлтсийн даргын энэ оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/21 дүгээр тушаалын дагуу АКМ, ПМ загварын галт зэвсэг ашиглан буудлагын дадлага сургалтыг зохион байгуулж нийт 71 алба хаагчийг тус тус бүрэн хамруулав.

Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2023 оны 28 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Монгол улсын Ерөнхийлөгч, зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит бие бялдарын бэлтгэлжилтийн түвшин тогтоох 1, 2-р шатны үзлэг шалгалтыг 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 133 алба хаагчийг хамруулж дүн мэдээг Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэст хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гарагт зохион байгуулсан “Ахисан түвшиний жөндөрийн дүн шинжилгээ”, “Төрийн албаны ёс зүйт манлайлал”, “Төрийн алба хаагчийн ёс зүйн, харилцаа, хандлага” зэрэг нийт 18 удаагийн сургалтад давхардсан тоогоор 350 алба хаагч хамрагдлаа.

Цагдаагийн хэлтсийн сургалтын нэгдсэн төлөвлөгөөнөөс гадна аймаг орон нутгийн төр захиргааны байгууллагаас төрийн алба хаагчийг чадавхжуулах, харилцаа хандлага, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулж буй сургалт, соён гэгээрүүлэх ажилд алба хаагчдыг тухай бүр хамруулан ажиллаж хэвшсэн.

Энэ оны 06 дугаар сарын 26-нд Соёлын яамнаас зохион байгуулсан “Соёлын сэргэлт 2023” аяны хүрээнд доктор Б.Баатархүүгийн “Монгол хүний эрхэмлэн дээдлэх үнэт зүйл ба ёс суртахууны асуудал” сэдэвт лекцинд 46 алба хаагч, “Залуучуудын манлайлал” аймгийн залуучуудын чуулга уулзалтанд 15 алба хаагчийг хамруулж аймгийн Залуучуудын хөгжлийн төв, lead Mongolia төслийн багийн Б.Болдсайхан “Залуу хүний хандлага ёс зүй, сэдэвт илтгэл Төрийн албаны зөвлөлийн зөвлөлийн гүшүүн Ц.Амартөгсөөр ахлуулсан ажлын хэсэг Говьсүмбэр аймагт ажиллах үед “Төрийн албаны шинэтгэл”, Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хууль”, “Төрийн алба хаагчийн ёс зүй харилцаа хандлага” сэдэвт хэлэлцүүлэг,

сургалтанд цагдаагийн хэлтсийн нийт алба хаагчдыг бүрэн хамруулсан. Аймгийн Засаг даргын тамгын газар, Удирдлагын академиас “Алсын хараа 2050” 14 хоногийн цахим сургалтанд 29 алба хаагчийг хамруулж “Батламж” гардан авсан. Хөдөлмөр халамж үйлчилгээний газар болон Польштехникийн коллежи хамтран зохион байгуулсан “Эрсдэлийн менежмент”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал” сэдэвт 12 цагийн сургалтад холбогдох алба хаагчийг бүрэн хамруулсан. Мөн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар болон Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан “Хөдөлмөрийн тухай хууль”-д орсон нэмэлт өөрчлөлт, байгууллагын удирдлага, хүний нөөц, ажил олгогч нарт мэдлэг олгох” сэдэвт сургалт, зөвлөгөөнд 10 алба хаагчийг хамрууллаа.

Соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, түүний үр дүнгийн талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/45 дугаар “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд тус цагдаагийн газраас хэрэгжүүлэх ажлыг 2 бүлэг, 18 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн төлөвлөгөөг тасаг, хэсэгт хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Тус цагдаагийн хэлтсээс 2023 оны эхний хагас жилд хууль тогтоомж, төрийн болон байгууллагын бодлого чиглэл, үйл ажиллагаатай холбоотой бусад албан бичгийг 109 удаа давхардсан тоогоор 3568 алба хаагчдад танилцуулсан, түүхэн замнал, шинжлэх ухаан, техник, технологийн ололтын талаарх мэдээлэл 5 удаа хийж нийт 225 алба хаагч хамрагдсан, соёл гоо зүйн хүмүүжил, мэдлэгийг дээшлүүлэх талаар 6 удаа арга хэмжээ зохион байгуулж 180 алба хаагч хамрагдсан, биеийн тамир спортын 5 төрлийн арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор нийт 230 алба хаагч оролцсон, музей, түүхэн дурсгалын газруудыг үзүүлэх 1 удаа 45 алба хаагчийг хамруулж, сонин, хэвлэл, радио, цахимаар зохион байгуулагдсан ажил, арга хэмжээний талаар 4 удаагийн мэдээлэл сурталчилгааны ажил явуулсан. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Биеийн тамир спортын арга хэмжээ зохион байгуулах” код-941 журмын 941.6-д заасан биеийн тамир, спортын хамтлагын үйл ажиллагаа эрчимжүүлж, Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд зохион байгуулагдах 15 төрлийн спортын аварга шалгаруулах тэмцээний төрөл хариуцах эрх бүхий албан тушаалтаны хуваарь, дотооддоо зохион байгуулах 12 тэмцээний хуваарийг байгууллагын даргаар батлуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагуудын дунд зохион байгуулагдсан 2023 оны “Модон барилдаан”-ын аварга шалгаруулах тэмцээнд 4 алба хаагч, “Туухай өргөлт”-ийн тэмцээнд 5 алба хаагчийг тус тус оролцуулж эмэгтэй төрөлд шагналт дэд, гутгаар байр, аймгийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохиогдсон “Марш тактик” тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээнд хэлтсийн 1, 2, дугаар баг шагналт байранд, бүх нийтийн крос гүйлтийн тэмцээнд нийт 16 алба хаагч хамрагдсанаас эмэгтэй төрөлд тэргүүн байр, эмэгтэйчүүдийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах боксын тэмцээнээс 1 алба хаагч дэд байранд, аймгийн спортын бага наадамд 35 алба хаагч хамрагдаж усан сэлэлтийн буухиа тэмцээнд дэд байр, олс таталтын тэмцээнд гутгаар байранд шалгарсан амжилтыг тус тус үзүүлсэн.

Тус хэлтсийн спорт хамтлагаас зохион байгуулах уралдаан тэмцээн, арга хэмжээний хуваарийн дагуу Эрүүгийн цагдаагийн тасгаас “Сагсан бөмбөг”, Шуурхай удирдлагын тасгаас “Дартс” зэрэг тэмцээн, Ахлагч нарын зөвлөлөөс “Модон барилдаан”, Мөрдөн байцаах тасгаас “Паурлифтинг”-ийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж нийт 7 тасгийн 8 баг, тамирчид оролцож эхний 3 байранд шалгарсан баг, тамирчдыг өргөмжлөл,

үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулав.

Монгол улсын соёлын гавъяат зүтгэлтэн, Монголын залуучуудын эвлэлийн шагналт яруу найрагч, цагдаагийн хурандаа Л.Гаваасүрэн агсны нэрэмжит дууны уралдаанд тус хэлтсийн 3 алба хаагч хамрагдаж 1 алба хаагч Сүлд чуулгын даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 25/112 албан бичгийн дагуу тэмцээний 2 дахь шатанд шалгарч гала тоглолтонд оролцсон.

Аймгийн Нийтийн номын сантай хамтран “Ном уншихын ач тус” сэдвээр алба хаагчдын дунд мэдээлэл хийлгэж “Боржигон өв соёл” сэдвээр АХА танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулж шалгарсан алба хаагчийг үнэ бүхий зүйлээр шагнасан. Алба хаагчдын дунд “Оюунлаг цагдаа” номын клубын үйл ажиллагааг эхлүүлж явуулын болон танхимын номын санг ажиллуулж байна. Хэлтсийн нийт алба хаагчдын нэрээр аймгийн нийтийн номын санд уншигчийн карт нээлгэж танхимаар болон гэрээр ном авч унших боломжийг бүрдүүлсэн.

Цагдаагийн хэлтсийн спорт зааланд алба хаагчдын хүүхдүүдийг анги хамт олон, найз нөхөд, гэр бүлийн хамт гар бөмбөг, сагсан бөмбөг, ширээний теннис, хөнгөн атлетикаар цаг харгалзахгүй хичээллэх боломжийг бүрдүүлж өгснөөр энэ оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 465 хүүхэд спорт заалаар үйлчлүүлсэн байна. Мөн “Хомбуу Доджо” карате бие бялдарын сургалтын төвд цагдаагийн ахлагч Э.Очбадрахыг сургагч багшаар бэлтгэн алба хаагчдын хүүхдүүдэд 7 хоног бүр карате бие бялдарын бэлтгэлжилтийн сургалтыг зохион байгуулан ажилласан.

Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үнэ цэнийг ойлгуулж, мэргэжлээ сонгоход нь чиг баримжаа олгох зорилгоор Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай хамтарч 2023 оны 01 дүгээр 27-ны өдөр ахлах ангийн 50 сурагчийг байгууллагын үйл ажиллагаатай танилцуулж танилцах аялал хийсэн.

“Эмэгтэйчүүдийн орон тооны бус зөвлөл”-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр хүртэл Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг алба хаагчдад сурталчилан таниулах, алба хаагчийн оюуны мэдлэгийг сайжруулах зорилгоор “Мэдлэгтэй чихэр” арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд 5 өдрийн өглөөний рапортаар “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Сахилгын дүрэм”, “Албан үүрэг гүйцэтгэх үед алба хаагч хүнтэй харилцах, биеэ авч явах байдал”,/код-921/, “Цэргийн нийтлэг дүрэм”-ийг сурталчилан таниулсан мэдээлэл бүхий чихрээр алба хаагчдыг дайлж 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр дээрх сэдвүүдээр бэлдсэн танин мэдэхүйн АХА тэмцээнийг зохион байгуулж тэргүүн, дэд байрыг шалгаруулж өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнаж урамшууллаа. Мөн орон тооны бус зөвлөлөөс олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулж 2023 оны 03 дугаар сарын 07-ний өдөр цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 3 эмэгтэй ахмад ажилтанг урьж “Залгамж-Холбоо” уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уулзалт хэлэлцүүлгээр ахмадууд алба хаагчдын дунд ажлын туршлага, ололт амжилт, алдаа оноогоо дэнслэн дурдатгал яриа өрнүүлж цагдаагийн хэлтсийн эмэгтэй алба хаагчдаас ахмад ажилтнуудад гарын бэлэг, гэр бүлийнх нь цахим мэндчилгээг үзүүлж гэнэтийн бэлэг барьлаа.

Энэ оны 05 дугаар сард эх орон байгаль, түүх соёлоо хайрлан хамгаалах, эх оронч иргэнийг төлөвшүүлэх зорилгоор зохион байгуулсан “Бидний бахархал” төслийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулиуд, Говьсүмбэр аймгийн Политехник коллежийн сурагч, оюутнууд, алба хаагч нарт цагдаагийн хэлтсийн дарга асан, цагдаагийн бэлтгэл дэд хурандаа С.Ганбат цагдаагийн албаны үнэт зүйл бахархал, мэргэжлийн онцлог сэдвээр уулзалт хийж нийт 810 иргэн хамрагдсан. Эхний хагас жилд цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 3 алба хаагчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, энэ үеэр тэдний ажил, амьдралын түүхэн замналыг харуулсан видео бэлтгэн алба хаагчдад үзүүлж ажил

амьдралын сургамжтай дурталгал яриаг алба хаагчдад хүргэж давхардсан тоогоор 156 алба хаагч хамрагдсан.

Цагдаагийн албаны болон дотоодын цэргийн байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх, “Цагдаагийн тангараг” давтах ёслолын арга хэмжээг энэ оны 5 дугаар сард аймгийн төр захиргаа, хууль сахиулах байгууллагын удирдлага, ахмад ажилтан, алба хаагчдын ар гэрийхэн зэрэг нийт 250 иргэдийг хамруулан зохион байгуулж энэ үеэр ЦЕГ-ын ахмадын хорооны гишүүн бригадын генерал А.Дулаанжаргал тус хэлтсийн 14 ахмад ажилтанг хүлээн авч уулзалт ярилцлага зохион байгуулсан. Төрийн болон хууль сахиулах байгууллагуудын “Залуу офицеруудын чуулган”-нд цагдаагийн хэлтсийн 12 залуу офицерыг цахимаар хамруулсан.

Эцэг эхийн зөвлөлөөс энэ оны 05 дугаар сард “Бүх хайрыг гэр бүлдээ” сэдэвт уулзалт өдөрлөгийг зохион байгуулсан. Уулзалт өдөрлөгт цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ар гэрийн 48 иргэн хамрагдсан ба тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, сонсохын зэрэгцээ “Азын хүрд”, “Гар бөмбөг-ийн тэмцээнийг тус тус зохион байгуулж шагнаж урамшууллаа.

Цагдаагийн хэлтсийн даргын “Талархал”, алба хаагчдаас гэр бүлийнхэндээ “Сэтгэлийн илгээмж” илгээснийг видео, болон ил захидал хэлбэрээр хүргэн, урлагийн үзүүлбэрийг үзүүлж сонирхууллаа.

“Жаргалтай хүүхэд нас” сэдэвт өдөрлөгийг 2023 оны 05 дугаар сарын 31-нд олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгууллаа. Уулзалт өдөрлөгт цагдаагийн хэлтсийн алба хаагчид тэдний ар гэр, хүүхэд багачууд нийт 150 гаруй хүн хамрагдсан ба “Боулинг”, “Дартс”, “Онч үгс”-ийн тэмцээн, уралдааныг тус тус зохион байгуулж шагнаж урамшууллаа. Урлаг, спорт, сурлагаараа амжилт гаргасан 5 хүүхдийг Цагдаагийн хэлтсийн даргын “Талархал”, эцэг, эхийн “Сэтгэлийн илгээмж” ил захидлыг хүргэж авъяаслаг хүүхдүүдийн урлагийн үзүүлбэрийг үзүүлж сонирхууллаа. Мөн хэлтсийн хүлэмжинд нарийн ногооны үрсэлгээг суулгаж, цэцгийн мандал тарьсан.

Алба хаагчдын нийгмийн асуудал, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөө, аймгийн засаг даргын хамтран ажиллах гэрээ, аймгийн 2020-2024 оны хөгжлийн хөтөлбөр, зэрэг баримт бичгүүдэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, алба хаагч нарын нийгмийг асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд шинээр болон шилжин томилогдсон алба хаагч нарын гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангахад хамтран ажиллах, амжиргааны түвшин, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөрт хамруулах зэрэг саналыг тусгуулан энэ оны эхний хагас жилийн байдлаар 2 алба хаагчийн гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангах ажлыг зохион байгуулав.

Бүтээлч ажил, шинэлэг ажил арга хэмжээний саналыг алба хаагч бүрээс авч нэгтгэн 2023 оны 01 дүгээр сарын 23-ний өдөр 26 заалт бүхий “Цагдаагийн хэлтсээс 2023 онд хийж хэрэгжүүлэх бүтээлч ажил, шинэлэг ажил арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулж цагдаагийн хэлтсийн даргаар батлуулан алба хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор бялдаржуулах өрөө, саун, спорт заал, алдрын танхим зэргийг нөөц бололцоогоо ашиглан засвар үйлчилгээ, тохижилтын ажлыг хийж алба хаагч нар хуваарийн дагуу үйлчлүүлж байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэг болон Шивээговь, Баянтал сумдын эрүүл мэндийн төвд нийт 71 алба хаагч, ажилтныг эрт илрүүлгийн эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулсан. Мөн “Сайн сайхан медикаль” SM эмнэлэгийн 8 эмчийг Улаанбаатар хотоос урьж ажлын байранд алба хаагч, ахмад настан, тэдний гэр бүл нийт 70 хүнийг

хамруулж 5 төрлийн үзлэг оношлогоог үнэ төлбөргүй зохион байгуулсан.

Аймгийн Улаан загалмайн хороонд 8 алба хаагчийн нэрсийг хүргүүлж хүнс, тэжээл, 2 алба хаагчийн ар гэрт нүүрс түлээний дэмжлэг үзүүлсэн.

Хэлтсийн даргын 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/15 дугаар тушаалаар “Үзэсгэлэн болгогч” хэмээх 17 дугаар жарны харагчин усан туулай жилийн хаврын тэргүүн сарын “Сар шинийн баяр”-г тохиолдуулан 36 ахмад ажилтанд хүндэтгэл үзүүлж, хамгийн өндөр настай 3 ахмад ажилтанд тавгын идээ, гарын бэлэг гардуулан нийт 2.441.190 төгрөг зарцуулсан. Алба хаагчдын ар гэрт цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, тэдний ажлын онцлогыг ойлгуулах таниулах ажил, арга хэмжээг зохион байгуулах зорилгоор тус хэлтсийн тасгийн дарга нар хариуцсан алба хаагчдын гэр орноор орж санал хүсэлтийг сонсож ажлын онцлогийг нь таниулах ухуулга яриа хийж хэвшсэн. Цагдаагийн хэлтсээс энэ оны 05 дугаар офицер, ахлагч, ар гэрийнхнийг дунд зохион байгуулсан 2 удаагийн хэлэлцүүлэг, 1 удаагийн уулзалт өдөрлөгт нийт 75 хүн хамрагдсан ба алба хаагч, ажилтны эрх ашиг, нийгмийн баталгааг хангах чиглэлээр гэр бүлийн 8 гишүүнээс гаргасан 9 төрлийн санал, 7 алба хаагчийн 7 саналыг нэгтгэн Соён гэгээрүүлэх албаны сургалтын хэлтэст хүргүүлсэн.

Алба хаагчдын ар гэрийнхний дунд энэ оны 05 дугаар сард “Бүх хайрыг гэр бүлдээ” уулзалт өдөрлөгийг зохион байгуулж санал хүсэлтийг нь сонсож ажилласан. Ар гэрийнхний дунд зохион байгуулсан уулзалтанд нийт 48 хүн хамрагдсан ба алба хаагчдыг орон сууцанд хөнгөлөлттэй үнээр хамруулах саналын дагуу “Мөнхийн Ундрага ХХК”-ний орон сууцанд 8 алба хаагчийг төрийн албан хаагчийн 3 хувийн зээлд хамруулахад санхүүгийн хөнгөлөлт үзүүлэх албан бичгийг аймгийн Төрийн банкны салбарт хүргүүлээд байна. Шинээр томилогдсон болон шилжин ирсэн 5 алба хаагчийг албаны орон сууцаар хангаж амьдрах нөхцөл байдлыг нь сайжруулсан. Алба хаагч, тэдний гэр бүлийнхэн байгууллагын 30 сот газарт төмс, сонгино, 2 хүлэмжинд өргөст хэмх, навч, амтат чинжүү, улаан лооль, газрын алим нарийн ногооны үрсэлгээг суулгаж усалгаа арчилгааг хийж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт заасны дагуу тухайн алба хаагчийг ээлжийн амралт эдлэх үед нь нэмэгдэл хоног, хугацааг бүрэн тооцож ээлжийн амралтыг бүрэн эдлүүлэхээр хувиар, томилгооны дагуу алба хаагчдыг амраасан. Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолд Цагдаагийн алба хаагчдад мэргэшлийн зэргийн урамшуулалыг 10-25 хувиар ажилласан жилийг харгалзан олгохоор заасны дагуу 10 алба хаагчдад зэргийн нэмэгдлийг олгуулж байна. Ардын хувьсгалын 102, Цагдаагийн байгууллагын түүхт 102 жилийн ойг тохиолдуулан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэгт ажилдаа идэвхи зүтгэл гарган бусдыгаа манлайлан ажилласан нэр бүхий алба хаагчдыг Төрийн дээд шагнал “Цэргийн гавьяаны одон”-оор 1, “Цэргийн хүндэт тэмдэг”-ээр 2, Хууль зүйн яамны шагнал “Хүндэт жуух бичиг”-ээр 2, Цагдаагийн ерөнхий газрын “Цагдаагийн гавьяа тэмдэг”-ээр 1, “Хүндэт жуух бичиг”-ээр 2, Цагдаагийн хугацааны цолоор “цагдаагийн дэд хурандаа цол”-оор 2, “цагдаагийн ахмад цол”-оор 1, “цагдаагийн ахлах дэслэгч цол”-оор 2, “цагдаагийн дэслэгч цол”-оор 4, “цагдаагийн сургагч ахлагч цол”-оор 1, “ахлах ахлагч цол”-оор 1, “ахлагч цол”-оор 1 нийт 12 алба хаагчийн шагнуулахаар материалыг холбогдох албадад хүргүүлэн ажилласан байна.

**Нутаг дэвсгэрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар
уламжлан шийдвэрлэсэн ажил, арга хэмжээ, төсөв хөрөнгө,
зарцуулалт, үр дүнгийн талаар**

Цагдаагийн хэлтсээс Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжүүлэхээр 9 бүлэг 31 заалт бүхий 301,8 сая төгрөгийн төсөв бүхий ажлын саналыг хүргүүлснээс 174,0

сая төгрөгийн төсөв батлагдсан. Энэ оны эхний хагас жилд 56.2 сая төгрөгийн төсвийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулаад байна. Замын цагдаагийн албаны чиглэлээр ашиглах өндөр хүчин чадал бүхий хурд хэмжигч төхөөрөмж 45,0 сая, “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээн зохион байгуулахад 2,4 сая, бэлэн бусын торгуулийн төхөөрөмжийн сунгалтын төлбөр 3.6 сая, энгэрийн камер 10 ширхэг 5.2 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн.

Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрт хамрагдаж байгаа болон бие даан хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар

Цагдаагийн ерөнхий газрын даргын “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт батлах” тухай тушаалаар батлан ирүүлсэн жагсаалтаас цагдаагийн хэлтэст хамаарах 59 бодлогын баримт бичгийн 104 заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, нэмэлтээр 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн мөн Захиргааны удирдлагын газрын даргын 5а/4548 албан бичгийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд агентлаг, байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хийсэн үнэлгээнээс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх 5 заалт бүхий төлөвлөгөө, 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар батлагдсан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн зорилт, шалгуур үзүүлэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус батлуулан зүйл заалтыг тусгасан төлөвлөгөө гарган хариуцах албан тушаалтнуудад хуваарилан баталгаажуулж биелэлт үр дүнг улиралаар тооцон ажилласан. гарган батлуулж, тасаг, хэсгийн дарга нарт хуваарилан өгч биелэлтийг хангуулан хяналт тавьж ажилласан.

Аймгийн засаг даргын тамгын газраас ирүүлсэн 2023 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт дагуу 22 бичгийг хяналтад авч, нэгжийн дарга, ахлах албан тушаалтнуудад хувиарлан эзэнжүүлж хууль тогтоомж тушаал шийдэрийн хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан. Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн Б/30 захирамжаар тус Цагдаагийн хэлтэс нь хяналт шинжилгээ үнэлгээний дүнгийн үзүүлэлт 82.4 %, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 84.2% дүгнэгдсэн.

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй “Нээлттэй Говьсүмбэр аймаг” хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хот, бусад аймаг, орон нутгаас шилжиж ирсэн 4 алба хаагчийн хаягийн бүртгэлд шилжилт хөдөлгөөнийг хийлгэж ажиллалаа.

Эхний хагас жилийн байдлаар алба хаагчдын 88 хувь нь Говьсүмбэр аймгийн хаягийн бүртгэлтэй байна.

Аймгийн Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагын дарга нарын уулзалт хэлэлцүүлгийг цагдаагийн хэлтсээс зохион байгуулж хуулийн байгууллагуудын алба хаагч ажилчдыг аймгийн хэмжээнд шинээр тавих теле хяналтын камерын үйл ажиллагааны чиглэлээр орон нутгийн хөгжлийн сангийн цахим санал хураалтанд оролцохыг уриалж энэ талаар шийдвэрт тусгасан.

Аймгийн прокурорын газартай хамтарсан зөвлөгөөнийг сар бүрийн 05-ны өдөр зохион байгуулж, мөрдөн шалгах ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах, гаргасан алдаа дутагдлыг дахин давтан гаргахгүй байх, удаашран шалгагдаж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалгалтын ажиллагааг түргэн шуурхай явуулах, яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тодорхой хэргүүдийг шалгаж шийдвэрлэх, ажил сайжруулах бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж сар бүрийн шийдвэрлэх хэргийн графикийг гаргаж шийдвэрлэлтийг эрчимжүүлэн ажиллаж хэвшсэн. Шүүхийн тамгын газартай хамтарч шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажилд тулгамдаж буй асуудал сэдвээр 2 удаагийн

уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж үр дүнг тооцох ажлыг хэвшүүлсэн.

Цагдаагийн хэлтсийн 2023 оны үйл ажиллагааны тайланг энэ оны 01 дүгээр сард аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Иргэний зөвлөлд, Шивээговь, Баянтал сумдын иргэдэд танилцуулах ажлыг тус тус зохион байгуулан 350 иргэнийг хамруулан гэр бүлийн хүчирхийлэл болон зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг тус тус зохион байгуулсан. “Алсын хараа 2050” Шинэ сэргэлтийн бодлого, “Хот хөдөөгийн сэргэлт”, “Нээлттэй Говьсүмбэр аймаг” хөтөлбөрийг сумдад танилцуулах, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, иргэдийн санал хүсэлтийг сонсож хүлээн авах, шийдвэрлэх зорилгоор энэ оны 5 дугаар сард Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдад аймгийн засаг дарга Г.Батсуурь иргэдтэй уулзах уулзалтанд хэлтсийн дарга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий алба хаагчид оролцож иргэдийн санал хүсэлтийг сонсож хариу өгч ажилласан.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 6/2236 дугаартай албан бичгээр ирүүлсэн Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагаас 2023 онд хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт”-ийг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. “Авлигын тухай ойлголт”, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан “Авлигаас урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа” журам /код-139/ 139.61в маягтыг алба хаагчдад тусгайлан танилцуулан тэмдэглэл хөтлөн зааварчилга өгөх зэрэг нийт 3 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 190 алба хаагчдыг хамруулав.

Тус Цагдаагийн хэлтсийн 2022 онд хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах эрх бүхий 39 алба хаагчдаас цахимаар хуулийн хугацаанд шинэчлэн гаргуулан авч баталгаажуулж, хадгаламжийн нэгж болгон Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт – Аюулгүй байдлын газарт 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор архивын нэгж болгон хүргүүлсэн. Энэ онд тасаг, хэсгийн даргын албан тушаалд 3, чиглэлийн ахлах 1, албан тушаал өөрчилсөн 1, шилжин ирсэн 3, шинээр томилогдсон 1, дэвшин томилогдсон 5 нийт 14 алба хаагчийн хөрөнгө орлого, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн. Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт – аюулгүй байдлын газрын даргын 2023 оны 6/809 дугаартай албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу албаны шалгалт, Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусган Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Ашиг сонирхлын зөрчлийн талаарх” маягтыг бөглүүлэн авч хэвшүүлсэн. “Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Мэдүүлэг гаргагчдад зориулсан гарын авлага”, “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага”, Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсийн даргын 2022 оны 5д/4631 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Авлигын криминологи - онолын чиг хандлага” зэрэг 5 төрлийн номыг тасаг, хэсгээр аялуулан бие даан судлуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллав. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Авлигаас урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа” журам (код-139)-ын 139.61в “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөхийг оролдсон тухай тэмдэглэл”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4, 22.5 дахь заалтаар

сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 73 алба хаагчдыг хамруулсан.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдын сахилга ёс зүйг сайжруулах, албан үүргээ гүйцэтгэх явцад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дээрх гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх талаар 2 удаа давхардсан тоогоор 145 алба хаагчаас баталгаа гаргуулан гарын үсэг зуруулж авсан. Цагдаагийн хэлтсийн алба хаагчдад “Авлигын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” сэдвээр 2 удаа 120 алба хаагчдад танхимаар сургалт зохион байгуулсан.

Дотоод хяналт аюулгүй байдлын газраас ирүүлсэн 9 төрлийн зурагт хуудас, гарын авлага хэлбэрээр бэлтгэсэн 59 материалыг хэвлүүлэн хэлтсийн хүлээлгийн танхим, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, Аймгийн засаг даргын тамгын газар зэрэг хүн олноор цуглардаг газруудад байршуулан Цагдаагийн хэлтсийн албан ёсны цахим хаягаар иргэд олон нийтэд хүргэх ажлыг тус тус зохион байгуулав. Авлигаас урьдчилан сэргийлэх мэдээллийн самбарыг хэлтсийн хүлээлгийн танхимд байршуулан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Алигын эсрэг хууль”, “Авлигын эсрэг ... нэгдье” аян, арга хэмжээний талаар зэрэг 18 мэдээллийг байршуулан сурталчлан ажиллав.

Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын энэ оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 3/82 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт”-ийн 2.4 дэх заалтын дагуу 2 удаагийн цахим шалгалтад бие бүрэлдэхүүнийг бүрэн хамруулав. Энэ оны эхний хагас жилийн байдлаар авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт 83.6 хувь хэрэгжсэн, байгууллага, алба хаагчдад хандсан 3 талархал ирснийг алба хаагчдад танилцуулан ажиллав. Энэ оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын алба хаагчдыг авлигаас ангид байлгах, урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэсний үр дүнд авлига, ашиг сонирхлыг зөрчилд холбогдсон алба хаагч бүртгэгдээгүй болно.

Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар

Эхний хагас жилийн байдлаар иргэн, байгууллагаас нийт 122 өргөдөл гомдол ирүүлснээс ажилд орох суралцахыг хүссэн 25, ажилд дахин орохыг хүссэн 3, ажил өөрчлөх шилжих 18, захиргааны чөлөө хүссэн 50, тэтгэвэр тэтгэмж орон сууц хүссэн 6, бусад 20 хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд журмын дагуу бүртгэлийг хөтөлж, сар бүр даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох албадад саналыг хүргүүлэн хариуг мэдэгдэж хэвшсэн.

Монгол Улсын Засгийн газрын “Иргэд олон нийтийн харилцах 11-11 төв”-өөс 3, Цагдаагийн ерөнхий газрын 126 тусгай дугаарын утсанд алба хаагчтай холбоотой 8 гомдол тус тус бүртгэгдсэн. Бүртгэгдсэн гомдол мэдээллийн дагуу шалгалтын ажиллагааг зохион байгуулан ажиллахад буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй 10, алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдсон 1, одоо гомдол, мэдээллийн үлдэгдэлгүй байна. Гомдол мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэн гомдол гаргагчид 100 хувь бичгээр хариу өгч ажилласан.

Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар

Монгол Улсын Засгийн газрын 01 “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгавар, 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн дэд, дэд дарга нараас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг тусгайлан бүртгэж, алба хаагчдад танилцуулж, сургалтыг зохион байгуулах төлөвлөгөө, хариуцах алба

хаагчийг томилж сар бүр даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж үр дүнг тооцон ажиллав.

Энэ оны эхний 6 сарын байдлаар нийт 3 алба хаагч сахилгын арга хэмжээ хүлээлснээс /тасгийн дарга 1, офицер 1, ахлагч 1/ байна. Сахилгын шийтгэл хүлээсэн байдалд дүн шинжилгээ хийхэд иргэнтэй зүй бус харилцсан, хариуцсан эргүүлийн чиглэлийг орхин, үүрэгт ажилдаа хайнга хандсан зөрчлүүд тус тус эзэлж байна.

“Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-нийг энэ оны 04 дүгээр сарын 04, 06 дугаар сарын 301-ний өдрүүдэд 2 удаа зохион байгуулж цагдаа дотоодын цэргийн анги байгууллагын хэмжээнд болон хэлтсийн сахилга ёс зүйн байдалд хийсэн дүн шинжилгээний танилцуулгыг алба хаагчид танилцуулж цагдаагийн хэлтсийн дарга сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр 2 удаа нийт 18 төрлийн үүргийг бичгээр давхардсан тоогоор 112 алба хаагчдад хүргүүлж үр дүн тооцон ажилласан. Зөвлөгөөний үеэр “Хувь хүний харилцаа хандлага сахилга ёс зүй” сэдвээр сэтгэл зүйч цагдаагийн ахмад Б.Наранцэцэг алба хаагчдад 1 цагийн сургалт зохион байгуулж сахилга ёс зүйн зөрчил дутагдалд холбогдоогүй хариуцсан ажилдаа хариуцлагатай ажилладаг 4 алба хаагчдад цагдаагийн хэлтсийн даргын “Талархал”-ыг хадгалуулав.

Цэргийн байнгын тэтгэвэр гарсан 4 ахмад ажилтныг урьж энэ оны 3, 6 дугаар сард уулзалт ярилцлага зохион байгуулж давхардсан тоогоор 126 алба хаагчийг хамруулсан. Байгууллагын сахилга, ёс зүй, алба хаагчийн харилцаа хандлага, багаар ажиллах чадварыг сайжруулах зорилгоор “Гэмт хэрэг, сахилга, ёс зүйн зөрчилгүй хамт олон болохын төлөө” болзолт уралдааны хүрээнд энэ оны 4 дүгээр сараас эхлэн “Өөрөөрөө үлгэрлэе” сэдэвт 5 сарын аяныг зохион байгуулан ажиллаж байна. Аяны хүрээнд “Сайн зөвлөгч”, ахлах бүрэлдэхүүний “Сайн дэмжигч”, офицер бүрэлдэхүүний “Сайн суралцагч”, ахлагч бүрэлдэхүүний “Сайн оролцогч”, энгийн ажилчдын “Сайн туслагч” уралдааны танилцуулга мэдээллийг алба хаагчдад хүргэж, салбар төлөвлөгөө, удирдамжийг гарган хэрэгжилтийг ханган ажилласан. Арга хэмжээний хүрээнд хэлэлцүүлэг 3 удаа, сургалт сурталчилгааны ажил 5 удаа зохион байгуулж нийт 360 алба хаагч хамрагдсан. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын сахилга ёс зүйг сайжруулах, албан үүргээ гүйцэтгэх явцад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дээрх гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх талаар 1 удаа 69 алба хаагч, гэмт хэрэг, сахилга, ёс зүйн зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 удаа 76 алба хаагчдаас баталгаа баталгааг тус тус гаргуулан авч, нэгжийн дарга нар хяналт тавин ажилласан.

Дотоодын хяналтыг сайжруулах чиглэлээр өдөр бүр мөрдөгч нарын гар дээр шалгаж байгаа хэрэг материалыг тулгаж, өдөрт хийх ажлыг төлөвлөж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг бүрт, шалгах, түүвэр төлөвлөгөөг хийлгэж, ажлын өдөр тогтмол 18:00 цагт гомдол, мэдээлэл, хэрэг материалыг шалгах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажилтай биечлэн танилцаж, үүрэг чиглэл өгч, 14 хоногт хийсэн ажлаа нэгтгэн танилцуулах, аймгийн Прокурорын газарт хэргийг ажиллагааны хугацаанд нь хянуулах зэрэг ажлыг зохион байгуулж хэвшүүлсэн.

Тасгийн дарга болон ахлах мөрдөгч нар мөрдөн байцаалтын хэрэг материал бүрийг уншиж мөрдөгч нарт ажлын чиглэл, зааварчилга тухай бүр өгч, мэдээллийн санд гомдол мэдээлэл, гэмт хэргийн шийдвэрлэлт хөдөлгөөнийг хянан баталгаажуулах, алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах талаар үүрэг чиглэл өгч, биелэлтийг тооцон ажиллав.

Цагдаагийн хэлтсийн 75 алба хаагчдаас ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх, сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх, нууцлал аюулгүй байдлыг хангах, цахим орчин дахь мэдээлэл, нууцлал, аюулгүй байдлын талаар баталгааны хуудсаар 3 удаа баталгаа авч, тасаг хэсгийн дарга нар хяналт тавьж ажилласан.

Байгууллагын дотоод хөдөлмөрийн зохион байгуулалтыг зөв оновчтой болгох, алба хаагч, ажилтаны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын цаг ашиглалтыг сайжруулах,

сахилга хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх талаар үр дүнтэй ажил, арга хэмжээг зохион байгуулах талаар алба хаагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулахад өглөөний рапортыг багасгаж ажлын бүтээмжийг сайруулах дийлэнх олонхын саналын дагуу өглөөний рапортыг Даваа, Пүрэв гаргагуудад явуулахаар багасгасан нь ажлын цагийн бүтээмжийг 4 цагаар нэмэгдүүлсэн зохион байгуулалтын арга хэмжээ болсон.

Санхүүгийн үйл ажиллагааны талаар

Цагдаагийн хэлтэс нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар батлагдсан төсвийн санхүүжилт 1,149,068,400.00 /нэг тэрбум нэг зуун дөчин есөн сая жаран найман мянга дөрвөн зуун/ төгрөг, гүйцэтгэл нь 1,101,903,856.52 /нэг тэрбум / төгрөг буюу 85.8 хувьтай байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 3,034,200 /гурван сая гучин дөрвөн мянга хоёр зуун/ төгрөг, гүйцэтгэл нь 7,326,000.00 /долоон сая гурван зуун хорин долоон мянган/ төгрөг буюу 240 хувиар давуулан орлогын төлөвлөгөө биелсэн.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан.Үүнд: цалинд 874,614,635.31 /найман зуун далан дөрвөн сая зургаан зуун арван дөрвөн мянга зургаан зуун гучин таван / төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 19,763,765.14 /арван есөн сая долоон зуун жаран гурван мянга долоон зуун жаран таван/ төгрөг, Байр ашиглахтай холбоотой тогтмол зардалд 84,327,306.07 /наян дөрвөн сая гурван зуун хорин долоон мянга гурван зуун зургаан/ төгрөг, Тээвэр шатахууны зардалд 30,105,000.00 /гучин сая нэг зуун таван мянган/ төгрөг, жижүүрийн бүрэлдэхүүний хоолны зардалд 13.950.000.00 /арван гурван сая есөн зуун тавин мянга/ төгрөгийг зарцуулсан байна.

Цагдаагийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон, аккрузал сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т зааснаар аудит хийлгэсэн ба “Өөрчлөлтгүй дүгнэлт авч байгууллагын ил тод санхүүгийн самбар, шилэн дансны цахим www.shilendans.gov.mn сайтад байршуулсан. Санхүү, төрийн сангийн хэлтэст сар бүрийн эхэнд төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлтийг сар бүрийн батлагдсан төсвийн хуваарийн дагуу гарган өгч батлагдсан төсвийн хуваариар гүйлгээг хийж ажилласан. Эд хариуцагчаас касс, бараа материал, үндсэн хөрөнгийн тайлангуудыг сар бүр тулгалт хийж үлдэгдлийг баталгаажуулж, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг үнэн зөв хийж нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн байгууллагын санхүүгийн сарын мэдээг сар бүр, санхүүгийн тайланг улирал бүр гаргаж, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанд болон Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хугацаанд гаргаж тайлагнасан.

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажлыг Сангийн сайдын 2021 оны 06 сарын 30-ны өдрийн 103 дугаар тушаалын хавсралт “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмыг баримтлан цагдаагийн хэлтсийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар цагдаагийн хэлтсийн шатахуун, шатах тослох материал нийлүүлэх нийлүүлэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж шатахуун, шатах тослох материал нийлүүлэх ГСАЦХ/202301001 нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 33 дугаар зүйлийн дагуу tender.gov.mn сайтад цахимаар зарласан.

Цагдаагийн хэлтсийн шатахуун, шатах тослох материалын жилийн төсөв 69,994,600.00 /жаран есөн сая есөн зуун ерэн дөрвөн мянга зургаан зуун/ төгрөг батлагдсан ба шатахуун, шатах тослох материал нийлүүлэх нээлттэй тендэрийн хурлыг энэ оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 17-ны өдрүүдэд зохион байгуулж, үнэлгээний хорооны

гишүүдийн 100 хувийн ирцтэйгээр хуралдаж, төндэрт “Сод Монгол Групп” ХХК шалгарч 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд шатахуун, шатах тослох материал нийлүүлэхээр гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Аж ахуйн чиглэлээр

Шинэ барилгын паарнууд цоорч үйл ажиллагаа явуулахад хүндрэл гарсан тул Аймгийн Онцгой комиссын даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дугаарт тушаалаар цагдаагийн хэлтсийн халаалтын системд зайлшгүй шаардлагатай засвар хийх шийдвэрийг гаргуулж 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 12-ны өдөр гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг хэсэгчилсэн шилжүүлсэн. Халаалтын системд засвар хийх ажлын зардлыг шийдүүлэхээр тус хэлтсийн барилгыг гүйцэтгэгч Грийн Ресурс ХХК-аас 79 ширхэг паар хүлээж авч хагарсан паарыг шинэ паараар солих ажил хийгдэж үйл ажиллагаа жигдэрсэн. Мөн халаалт, цэвэр усны зардлыг хэмнэх зорилгоор хуучин 6 корпусын халаалтыг 5 сард зогсоож Санхүү аж ахуйн албанд албан бичиг хүргүүлж 5 сарын халаалтын зардлыг 4 сарын санхүүжилтээр авсны үр дүнд төлбөрийн өргүй гарсан. Эхний хагас жилд цагдаагийн хэлтсийн шинэ барилгын бохирын шугам 2 удаа хөлдөж, бөглөрсөнийг гэсгээж, бөглөрөлийг гарган, дахин хөлдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан. Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн А0102 авто зам дагуу байрлах замын цагдаагийн пост /Шивээговь суманд байрлах/, Сүмбэр сумын нутаг дэвсгэрт байрлах замын цагдаагийн постонд тохижилтийн засвар үйлчилгээ хийж Шивээговь сумын Цагдаагийн хэсгийн гадна, дотор хэсэгт камержуулалт, бялдаржуулах өрөөнд засвар үйлчилгээ хийж ажиллав. Монгол улсын Үндэсний аудитын газраас 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр ажлын хэсэг ирж тус хэлтсийн барилгын чанар байдлыг газар дээр нь шалгаж гүйцэтгэгч байгууллагаар агааржуулалтын хоолойн дээвэр дээрх орой хэсгийг будаж шохойдох, дээврийн хүрээ хийх, цонхны тавцанг хөдөлгөөнгүй бэхлэх, дээврийн ус тогтсон хэсгийг ус тогтохгүй болгож усны хаялага хийх, гадна пасатны хууларсан хэсгийг засах, цууралт өгсөн хэсгийг будаж шохойдох, цоорсон паарыг сольж дуусгах, дээврийн хонгилын гадна пасатыг засах зөвлөмж өгсөний дагуу засварын ажлуудыг барилгын гүйцэтгэгч Грийн Ресурс ХХК-тай хамтран зохион байгуулж зөвлөмжийг 100% хэрэгжүүлсэн.

“Тээврийн хэрэгслийн бүрэн хариуцлагын гэрээ” -г хариуцсан 17 алба хаагчидтай байгуулж “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”, “Ажлын байранд мөрдөгдөх аюулгүй ажиллагаа”-ны зааварчилгааг өдөр бүр ээлжинд гарч байгаа цагдаа жолооч нар болон энгийн ажилтнуудад танилцуулж тасгийн даргаар баталгаажуулан гарын үсэг зуруулж хэвшсэн. Замын цагдаагийн постонд тавигдсан цахилгаан халаагуурын ажиллагаанд хяналтыг 7 хоног тутамд шалгаж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ний 3/92, Дотоод хяналт аюулгүй байдлын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 6/2913 албан бичгийн дагуу “Эрүүл аюулгүй цэвэр орчин бүрдүүлэх” уриан дор 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр 14 цагт Сүмбэр сумын 3-р баг “Сүмбэр Гарден” цэцэрлэгт хүрээлэнгийн 18 га талбайн хог хаягдлыг цэвэрлэх ажилд тус цагдаагийн хэлтсийн 65 алба хаагчийг хамруулан зохион байгуулан ажиллалаа. Алба хаагчдад Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ний 3/92, Дотоод хяналт аюулгүй байдлын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 6/2913 албан бичиг, аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж гарын үсэг зуруулж баталгаажуулсан. Сүмбэр Гарден цэцэрлэгт хүрээлэнгийн 18 га талбай, хүүхдийн тоглоомын талбай 3 төрлийн хөшөөг угааж, 1 тонн хогийг ачиж хогийн цэгт хаясан. Бүх нийтийн цэвэрлэгээний талаар Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтсийн фэйсбүүк хуудсанд мэдээлэл байршуулж орон нутгийн олон хүн ихтэй зарын группуудад түгээлт хийж үйл ажиллагаагаа сурталчилан ажиллаа.

Хөрөнгө оруулалтын чиглэлээр

Говьсүмбэр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн №11 "Эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай" захирамжаар аймаг, сумдын төвийн камержуулалтын ажил 44,745,578.00 /дөчин дөрвөн сая долоон зуун дөчин таван мянга таван зуун далан найман/ төгрөг, эрүүлжүүлэх байрны бохир усны шугам холбох, дээвэр засварын ажил 59,707,921.00 /тавин есөн сая долоон зуун долоон мянга есөн зуун хорин нэгэн/ төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан.

Цагдаагийн ерөнхий газрын хангалт үйлчилгээний төвөөс энгэрийн камер WA7D нэг бүрийн үнэ 575,0 мянган төгрөгний 5 ширхэгийг хүлээн авч хэлтсийн бусад хангамжийн материалын орлогод бүртгэн үйл ажиллагаандаа ашигласан.

Сэтгэл зүйчийн ажил арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар

Цагдаагийн Ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагч ажилтаны сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, чиглэлээр 2023 онд хийж гүйцэтгэх ажлын ажлын төлөвлөгөө"-ний дагуу 13 заалт бүхий салбар төлөвлөгөөг цагдаагийн хэлтсийн даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан.

Алба хаагчдаас цагдаагийн байгууллагын цахим сангийн "Миний булан" хэсгийн сэтгэл зүйн судалгаа хэсэгт байршуулсан судалгааг авч, боловсруулан санал дүгнэлт гаргаж ажилласан бөгөөд судалгаанд стресс болон ажлаас халшрах хам шинж, нойргүйдэлийн судалгаагаар өндөр илрэлтэй судлагдсан 5 алба хаагчидтай нэг бүрчлэн уулзаж, судалгааны дүн, урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөөг 2, сургалтыг 1 удаа зохион байгууллаа.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021-2023 оны соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйг төлөвшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажлын байрны зөрчил, зөрчилдөөнийг бууруулах чиглэлээр "Өөрөөсөө өөрчлөлтийг эхэл", "Эрүүл биед саруул ухаан оршино" зөвлөмж, мөн алба хаагч, ажилтны бухимдал стрессийг бууруулах, тайвшруулах, идэвхжүүлэх, хамт олны таатай уур амьсгалыг бий болгох зорилгоор "Стрессийн менежмент", "Стресст үзүүлэх хариу үйлдэл" сургалтад 35 алба хаагч, ажлын байранд хийх дасгал хөдөлгөөний зааврыг бэлтгэн боловсруулж гарын авлага бэлтгэн 35 алба хаагчид хүргүүлсэн зэрэг ажил арга, хэмжээг тус тус зохион байгуулав.

Хүний нөөцийн цахим сангийн сэтгэл зүйн судалгаа хэсэг дахь стресст үзүүлэх хариу үйлдэл, стресстэй тэмцэх арга, ажлаас халшрах хам шинжийг илрүүлэх сорил, сэтгэл түгшилтийг илрүүлэх асуумж, нойргүйдлийн зэргийг тодорхойлох асуумж, сэтгэл гутрал судалгааг тестэд нийт 77 алба хаагчийг тус тус сэтгэл зүйн судалгаанд хамруулсан. Цагдаагийн байгууллагын цахим санд байршуулсан сэтгэл зүйчдын дунд зохион байгуулсан "Видео хичээл" илтгэх урлагын уралдааны шилдэг бүтээлүүдийг алба хаагчдаар судлуулах ажлуудыг зохион байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Б/905 дугаартай тушаалаар тус хэлтэст сэтгэл зүйчийг томилуулаад байна.

Бусад ажлын талаар

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Цагдаагийн ерөнхий газар болон бусад албад, төрийн болон төрийн бус байгууллагаас нийт 2127 албан бичиг ирүүлснээс хариутай 786 албан бичиг хүлээн авч, 621 бичгийн хариуг заасан хугацаанд нь хүргүүлсэн. Одоо хяналтад байгаа 175 албан бичиг байна.

Цагдаагийн ерөнхий газар болон бусад байгууллагууд руу 1035 албан бичиг хүргүүлж, тусгай шуудан 23 удаа хүлээн авч, 34 удаа явуулж ажиллав.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд дарга, дэд дарга нараас ирүүлсэн 30 үүрэг ажлын чиглэлийг бүртгэн холбогдох албан тушаалтанд шилжүүлж ажилласан.

Алба хаагчдын сахилгын хураангуй, дэлгэрэнгүй, албаны шалгалт, алба хаагчтай холбоотой өргөдөл, гомдол, алба хаагч өртөж, хохирсон талаарх, иргэдээс байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, албаны сургалт, соён гэгээрүүлэх ажлын болон хүний нөөцийн хөдөлгөөний тайлан мэдээг тус тус хугацаанд нь холбогдох албадад хүргүүлж ажилласан.

Хэлтсийн даргаас тасаг, хэсгийн дарга нарт, тасаг, хэсгийн дарга нараас алба хаагчдад өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлтүүдийг тухай бүр тооцож хэвшүүлсэн. Цагдаагийн хэлтсийн даргаас өгөгдсөн нийт 5 удаагийн үүрэг, чиглэлийн биелэлтийг гаргаж, үр дүнг тооцсон байна.

Цагдаагийн хэлтсийн 2022 онд үүссэн архивыг тасаг хэсгээс хүлээн авч, 2022 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг Цагдаагийн хэлтсийн баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар батлуулж Цагдаагийн ерөнхий газрын төв архивт хүргүүлсэн.

ХОЁР: ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Эрүүгийн цагдаагийн тасагт гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 68 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 17, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 32, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан 41 гомдол мэдээллийг тус тус шийдвэрлэсэн. 21 холбогдогчтой 48,500,000 төгрөгний хохиролтой эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 17 хэргийг илрүүлж, 14 хэргийг харъяаллын дагуу мөрдөн байцаах тасагт шилжүүлэн, 12 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, бусад газар, хэлтэст 7 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж, одоо эзэн холбогдогч нь тогтоогдоогүй нийт 72 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Эрэн сурвалжлах ASAP санд 2023 оны эхний хагас жилийн байдлаар оргодол этгээд урьд оны үлдэгдэл 2, энэ онд 3, нийт 5 этгээдийг зарлаж, олж тогтоосон-5, одоо эрэн сурвалжилж байгаа оргодол байхгүй. Урьд онд гэмт хэрэгт сэрдэгдсэн 2, энэ онд 14, нийт 16 этгээдийг эрэн сурвалжилж, үүнээс 10 этгээдийг олж тогтоосон.

Одоо гэмт хэрэгт сэрдэгдсэн 6 этгээдийг эрэн сурвалжилж байна. Шүүхээс даалгасан хүнээр урьд онд 4 иргэнийг, энэ онд 21, нийт 25 иргэнийг зарлаж, 10 иргэнийг олж тогтоосон.

Оршин суугаа газраасаа сураггүй алга болсон урьд онд 1, энэ онд 7, нийт 8 хүнийг эрэн сурвалжилж, 7 хүнийг олж тогтоосон. Одоо 1 иргэнийг эрэн сурвалжилж байна. Хулгайлагдсан тээврийн хэрэгсэл урьд оны үлдэгдэл 5, энэ онд зарлаагүй, нийт 5 тээврийн хэрэгслийг эрэн сурвалжилж байна. Эд зүйл урьд оны үлдэгдэл 14, энэ онд шинээр байхгүй, 5 эд зүйлийг олж тогтоосон бөгөөд өнөөдрийн байдлаар 9 эд зүйл эрэн сурвалжилж байна.

Зөрчил үйлдсэн этгээд энэ онд 21 зарлаж 19 этгээдийг олж тогтоон одоо 2 этгээдийг эрэн сурвалжилж байна. Эрэн сурвалжлалтын хувь 87,7%-тай байна.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “ASAP” санд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал амьтан, эд зүйлийн мэдээллийг оруулахдаа хэргийн ангиллыг үнэн зөв, бүрэн гүйцэд оруулж, эрэн сурвалжлагдаад олдоогүй байгаа хүн, эд зүйлийн талаар зохиомлоор эрэн сурвалжлалтыг хааж, дүн мэдээнд зөрүүтэй байдал гаргахгүй байх талаар алба хаагчдыг үүрэгжүүлэн ажилласан. Нийт бие бүрэлдэхүүний эрэн сурвалжлах “ASAP” санд хандаж байгаа хандалтын тоог сарын ажил дүгнэх хурлаар хэлэлцүүлж, шалгуур үзүүлэлт болгон хэвшүүлсэн.

Энэ эхний хагас жилийн байдлаар гэмт хэргийн илрүүлэлт 60,4 хувьтай байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 7,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Мөрдөн байцаалтын чиглэлээр

Энэ оны эхний 06 сарын байдлаар иргэн, аж ахуй нэгж байгууллагаас нийт 114 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас гомдол мэдээллээс эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 27, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 30, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 47, харьяаллын дагуу шилжүүлсэн 4, одоо 6 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй, үүнээс хугацаа алдсан гомдол мэдээлэлгүй 100 хувь хуулийн хугацаанд мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.

Хэрэг бүртгэлтийн энэ оны 47, урд оны 17 нийт 64 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 26 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 19 хэргийг хааж, 9 хэргийг харьяаллын дагуу шилжүүлэн, 10 хэргийн үлдэгдэлтэй байна.

Мөрдөн байцаалтын урд оны 6, шүүх, прокуророос нэмэлтээр буцсан 2, энэ оны 60 нийт 68 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулан, 1 хэргийг нэгтгэн, 2 хэргийг хэрэгсэхгүй болгон, 63 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлж, одоо 2 хэргийн үлдэгдэлтэй байна.

Шүүхэд 63 хэрэг шилжүүлж, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор мөрдөгчийн мэдэгдэл 100 хувь бичиж хариу авалт 85 хувьтай байна. Гомдол мэдээллийг хүлээн авч бүртгэн нэн даруй хугацаанд цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд оруулж, шийдвэрлэлтэнд хяналт тавих зорилгоор нийт бие бүрэлдэхүүнд өдөр бүр танилцуулж хэвшүүлсэн.

Замын цагдаагийн албаны чиглэлээр

Аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх босоо тэнхлэгийн А0101, А0102 дугаарын улсын чанартай хатуу хучилттай нийт 110 км замд болон 24 цагийн үйл ажиллагаатай байнгын хяналтын пост 1, хөдөлгөөнт эргүүлийн автомашин 2 хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллалаа. Цагдаагийн хэлтсийн жижүүрийн шуурхай албаны тусгай дугаарын 102 утсанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн зам тээврийн ослын 22 гомдол, мэдээллийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны / код 202 /-ын дагуу хүлээн авснаас, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 10, зам тээврийн осол 12 бүртгэгдэж, осол хэргийн улмаас нас барсан 2, гэмтсэн 14 хүн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүртгэгдсэн зам тээврийн осол хэрэг 4.4 дахин, хүн гэмтсэн осол хэрэг 7 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж замын хяналт шалгалтаар 10095 зөрчил илрүүлэн ажилласан. Үүнээс бэлэн бусаар 9803 зөрчил 209.745.500 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, цагдаагийн байгууллагын АСАП санд эрэн сурвалжлагдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эд зүйлс, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд, тээврийн хэрэгсэл 16 олж тогтоон, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 194 зөрчил, эрхийн үнэмлэхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 82 зөрчлийг тус тус илрүүлэн Монгол Улсын Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцон ажилласан. Тус тасаг нь энэ оны эхний 6 сарын байдлаар иргэд, аж ахуй нэгж байгууллагаас 276 зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл хуулийн дагуу хүлээн авч шалган шийдвэрлэн ажилласан. Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”-ын 1 дүгээр хавсралтын 1.2 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж Зам тээврийн ослын үед шийтгэлийн хуудас 1, 2 бичиж байгаа тохиолдолд цагдаагийн байгууллагын зөрчлийн санд шивж оруулахдаа зам тээврийн осол үйлдсэн этгээд эсэхийг

тийм /5 оноо хасах/ төлөвийг сонгож ямар нэгэн алдаа дутагдалгүй ажиллаж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дахь заалтын дагуу тогтоосон хугацаанд торгуулийг нөхөн төлөөгүй иргэдийн материалыг шүүн гаргаж энэ оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Говьсүмбэр аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 10 ширхэг материалыг эрх бүхий албан тушаалтны хүсэлтийг хүргүүлэн ажиллахад шүүхийн 485 дугаартай зөрчлийн материалыг хүлээн авч шийдвэрлэсний дагуу 04 дүгээр сарын 07-ны өдрийн 2023/ш33/06, 2023/ш33/14, 2023/ш33/13, 2023/ш33/16, 2023/ш33/17, 2023/ш33/12, 2023/ш33/15, 2023/ш33/07, 2023/ш33/10, 2023/ш33/09 захирамж гарч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар албадан гүйцэтгүүлсэн. Мөн тээврийн хэрэгслүүдийн торгуулийг шүүж үзэж бэлэн бус торгуулийг төлөх хугацаандаа төлөөгүй 168 жолоочийн 10.195.000 төгрөгийг торгуулийг нөхөн төлүүлж ажилласан байна.

Тээврийн цагдаагийн албанаас ирүүлсэн 2023 онд төв, орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдах нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу “Гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Ачааны автомашины бүрэн бүтэн байдал, ачаа тээвэрлэлт”, “Мотоциклийн бүртгэл”, “Уусан бол бүү жолоод” зэрэг 13 арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө гарган зохион байгуулан биелэлт үр дүнг тооцон хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. Мөн Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, замын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах зорилгоор Говьсүмбэр аймгийн ГХУСАЗСЗ, Аймгийн Прокурорын газар, Цагдаагийн хэлтэс, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцуулан 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр “Замын тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах нь” сэдэвт хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулсан. Уг зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллагад танилцуулан Говьсүмбэр аймгийн нийт нутаг дэвсгэрт “Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих” гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг таслан зогсооход чиглэгдсэн “Аюулгүй зам-Архигүй жолооч” 5 сарын аяныг зохион байгуулан хамтран ажиллаж байна.

Мөн замын хөдөлгөөнд оролцож байгаа иргэд, жолооч нарт зам тээврийн осол гарахад нөлөөлдөг шалтгаан, нөхцлийг багасгах, гарч болзошгүй зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтарсан зөвлөгөөн 2, 14 байгууллагын 319 ажилтан алба хаагч нарт “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Нийтийн хэв журам хамгаалах ажлын чиглэлээр

Нийтийн хэв журам хамгаалах тасгаас хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгээс цагдаагийн байгууллагад холбогдох заалтуудын биелэлт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний холбогдох заалтуудын биелэлт болон дээд шатны байгууллагаас ирүүлсэн 104 удаагийн үүрэг даалгавар, ажлын чиглэл, албан бичгийн хугацаанд нь гаргаж, Цагдаагийн ерөнхий газар, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, болон холбогдох газруудад тус тус хүргүүлэв.

Нийтийн хэв журам хамгаалах тасаг нь Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан орон тоогоор тасгийн дарга 1, ахлах байцаагч 2, хэсгийн байцаагч 2, эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч 3, саатуулах байрны жижүүрийн цагдаа 3, эргүүлийн цагдаа 6, харуулын цагдаа 3, хамгаалалтын цагдаа 1, сумын цагдаа 1, багийн цагдаа 2, нийт 24 орон тоотойгоос одоо тасгийн дарга 1, эрүүлжүүлэх саатуулах байрны эмч 1, эргүүлийн цагдаа 1 нийт 3 орон тоо дутуу ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран баар, караоке, дэлгүүр, худалдааны төвүүдийн захирал, эрхлэгч нарт “Согтууруулах ундааны

эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль"-ийг хэрэгжүүлэх, сурталчилах зорилгоор сургалт зохион байгуулж ажилласан. Сургалтад давхардсан тоогоор 68 аж ахуйн нэгжийн дарга, захирал хамрагдсан.

Мөн аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн А/18 "Сар бүрийн 25-ны өдөр аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, үйлчлэхийг хориглох тухай" захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 46 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллахад ямар нэг зөрчил илрээгүй.

Хариуцсан нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 8 байгууллагын 135 ажилтан, алба хаагчдад "Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулиар сургалт зохион байгуулсан. Мөн орон нутгийн "АА" бүлэгтэй хамтран архины хамаарал бүхий 35 иргэнд согтууруулах ундааны хор уршиг, түүнээс татгалзах, соён гэгээрүүлэх яриа таниулга хийсэн. Хууль бусаар гар дээрээс архи, согтууруулах ундаа худалдан борлуулах зөрчлийг таслан зогсоох чиглэлээр "Шаг", "Буудал", "Үзлэг шалгалт" зэрэг тусгай арга хэмжээнүүдийг зохион байгуулж, үр дүнг тооцсон. Арга хэмжээний үеэр зөрчил гаргасан 15 иргэнийг Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцож, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж ажилласан.

Эрүүлжүүлэх саатуулах, баривчлах байранд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчил гаргасан нийт 62 хүнийг эрүүлжүүлсэн нь урд оны мөн үеэс 231-ээр буурсан байна.

Цагдаагийн хэлтсээс Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар баталсан "Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр" журмын дагуу баривчлагдсан 115 иргэнд зан үйлд нөлөөлөх албадан сургалт зохион байгуулсан.

Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2021 оны А/44 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон "Албадан эрүүлжүүлэх" /Код-629/-ыг алба хаагчдад танилцуулан, эрүүлжүүлэх байранд иргэдийг хүлээлгэн өгөх, эрүүл мэндийн байгууллагад үзүүлсэн талаарх тэмдэглэлийг холбогдох хуулийн заалттай хувиан өгч эргүүлд ажиллах алба хаагчдаас тухай бүр ажил үүрэг гүйцэтгэхдээ ашиглаж байна.

Тус цагдаагийн хэлтэс нь Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, Цагдаагийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн байгууллага, Цагдаагийн ерөнхий газар болон дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан тушаал, шийдвэр, журам, зөвлөмж, үүрэг, ажлын чиглэлийг нэг мөр хэрэгжүүлж, хэлтсийн удирдах бүрэлдэхүүн болон алба хаагчдад цаг үеийн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг хүргэн, нэгдсэн удирдлагаар ханган ажилласан.

Эхний хагас жилийн байдлаар Сүмбэр сумын 4 дүгээр багийн нутагт энэ оны 1, 4 дүгээр сард бүртгэгдсэн малын мялзан, цэцэг, Шивээговь сумын 1, 2 дугаар багийн нутагт 05 дугаар сард гарсан бог малын цэцэг өвчний үеийн 3 удаагийн хязгаарлалтын болон хорио цээрийн дэглэмийн үеийн хамгаалалтанд 7 байршилд давхардсан тоогоор 12 алба хаагч үүрэг гүйцэтгэж ажилласан. Монголын уламжилалт Сар шинийн баяр амралтын өдрүүдэд хэлтсийн нийт бүрэлдэхүүнийг хамруулан 7 хоногийн эргүүлийн хуваарийг гарган батлуулж томилгоот алба хаагчдад үүрэг чиглэл өгч, хяналт тавьж зөрчил дутагдалгүй ажилласан. Аймгийн Засаг даргын тамгын газрын цэргийн штаб, Биеийн тамир спортын газар хамтран "Монгол цэргийн өдөр" Орчин цагийн зэвсэгт хүч үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойг тохиолдуулан 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан "Кросс" гүйлтийн хамгаалалт, Сүмбэр сум 5 дугаар багийн нутагт зохион байгуулагдсан "Уяан товог 2023" 9 насны хурдан морины уралдаан, "Их Сансар" хайрханыг тахих, Баянтал суманд "Сүлд овоо"-ны тахилга, Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Төрийн албаны 2

удаагийн шалгалт, Элсэлтийн ерөнхий шалгалт, Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгууль зэрэг 15 удаагийн хамгаалалтыг зохион байгуулж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны А/64 дугаар тушаалаар баталсан “Штабын бүрэлдэхүүн ажиллах журам”-ын дагуу тус цагдаагийн хэлтсийн Штабын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулж, нийтийн эмх замбраагүй байдлын үед ажиллах болон, Онцгой нөхцөл байдал, Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөө зэргийг шинэчлэх ажлыг зохион байгуулж томилгоот бүлэг, аравтын хуваарийг шинэчлэн гаргаж батлуулсан.

Нийтийн эмх замбраагүй байдал үүссэн үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Тагнуул, Онцгой байдлын газартай хамтран ажиллах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулсан ба уг төлөвлөгөөнд жагсаал цуглаан гарч болзошгүй цэгүүдэд хэрхэн хамгаалалт, зохицуулалт хийх, байгууллагуудын гүйцэтгэх чиг үүрэг, хүн, хүчний тооцоо судалгааг тусгасан.

Гудамж талбай, олон нийтийн газар үйлдэгдсэн 10 гэмт хэрэг бүртгэгдсэн урьд оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

Сүмбэр сумын 3-р багийн нутаг дэвсгэрт шинээр суурилуулах камерын тендерт шалгарсан “Баяжих-Өөдөс” ХХК нь Сүмбэр сумын 3 баг Нарамдал хотхонд шинээр 7 цэгт PTZ, хайрцаг, свич, уртасгагч, медиа конвертер зэрэг тоног төхөөрөмжийг суурилуулж, цахилгааны холболтыг хийсэн. Нийт 18 цэгт тавигдсан хуучин хяналтын камеруудыг Bullet камераар сольж суурилуулан, свич, медиа конвертер зэрэг холбогдох хэрэгслийг сольсон.

Мөн Сүмбэр сумын 1,2 дугаар багийн нутаг дэвсгэрт ажиллахгүй, засварлуулах, солих шаардлагатай камеруудын судалгааг 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр шинэчлэн гаргаж гудамж талбайд 20, хөдөлгөөнт 8, Hikivision 32ch 4k Deepinmind 2, хард диск 8, медиа конвертор 10, Поё свич 30, дагалдах хэрэгслүүдийг засварлуулахаар аймгийн засаг даргын тамгын газарт 50,288,000 төгрөгийн төсвийн саналыг хүргүүлж 13,303,000 төгрөгийн зардлыг шийдвэрлүүлж засварын ажлыг хийснээр өнөөдрийн байдлаар нийт 55 хяналтын камер ажиллахаас 54 камер хэвийн ажиллагаатай байна.

Олон нийтийн цагдаа нарт ажил үүргээ гүйцэтгэж байхдаа биеэ зөв авч явах, иргэдтэй зөв боловсон харьцах, дүрэмт хувцсыг цэвэр үзэмжтэй, дүрмийн дагуу өмсөж, өөрсдийн болон хамтран үүрэг гүйцэтгэж буй ажилтныхаа аюулгүй байдлаа хангаж ажиллах талаар 1 удаа зааварчилга өгч баталгаа гаргуулан авсан.

Явган болон хөдөлгөөнт эргүүлд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын албан үүргээ гүйцэтгэх хугацаанд нь иргэдээс ирүүлсэн дуудлага, мэдээлэл нэг бүрийг энгэрийн камерт бичлэг хийж байгаа байдалд тасгийн дарга, ахлах байцаагч нар хяналт тавьж ажилласан .

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ахлах байцаагч 1, харуулын цагдаа 3, хамгаалалтын цагдаа 1 гэсэн орон тоотойгоор үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа ба харуулын болон хамгаалалтын цагдаа нар 24 цагаар хамгаалалтын үүрэг гүйцэтгэх, шүүх хурлын дэг сахиулах, хэв журам сахиулах явган эргүүлд тус тус үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчдаас шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийт 152 удаа 3648 цагийн үүрэг гүйцэтгэн ажилласан.

Говьсүмбэр аймаг дахь шүүхээс зарлагдсан эрүүгийн хэргийн 64, иргэний хэргийн 96, захиргааны хэргийн 18, зөрчлийн хэргийн шүүх хурал 149, давж заалдах шатны 11, хянан магадлангийн 34, нүүдэллэн ажилласан 9 нийт 381 шүүх хуралд дэг сахиулж ямар нэг зөрчил дутагдалгүй ажилласан.

Дээрх шүүх хуралд шүүгч 428, улсын яллагч 258, нарийн бичгийн дарга 372, өмгөөлөгч 196, хохирогч 38, шүүгдэгч 72, нэхэмжлэгч 126, хариуцагч 102, ялтан 34,

холбогдогч 57, бусад 136, нийт 1819 оролцогчийг шүүх хуралд оролцоход нь хяналт тавьж, дэг сахиулж ажилласан.

Шүүхийн байрны гадна болон дотор аюулгүй байдалд хяналт тавьж 24 цагаар үүрэг гүйцэтгэх хугацаанд иргэдийг зохих журмын дагуу шүүхийн байранд нэвтрүүлсэн. Мөн өглөө бүр шүүхийн байрны камерын бичлэгийг шүүхийн тамгын газраас болон ахлах байцаагч, тасгийн дарга нараас шалгаж харуулын цагдаа нарт үүрэг чиглэл өгч, өдөр тутам хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллаж байна.

Эрэн сурвалжлах “ASAP” санд энэ онд эрэн сурвалжлалт зарласан 21 иргэнийг эрэн сурвалжилж ажиллан 10 иргэний оршин сууж байгаа газрыг олж тогтоон эрэн сурвалжлах “ASAP” санд хаалт хийж одоо үлдэгдэл 11 иргэний хариуцагчийг эрэн сурвалжлан ажиллаж байна. Үүнээс олж тогтоох боломжтой 5, Монгол Улсын хилээр гадаад улсруу нэвтэрсэн 6 байна.

Цагдаагийн хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Шүүхийн тамгын газартай хамтарсан зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулсан.

Шуурхай удирдлагын албаны чиглэлээр

Тайлангийн хугацаанд жижүүрийн шуурхай албанд гэмт хэргийн 173 зөрчлийн 412, нийт 585 дуудлага, мэдээлэл хүлээн авч ажилласан.

Иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 173 дуудлага, мэдээллийг өнгөөр нь авч үзвэл: хулгайлах- 9, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 40, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3, бусад 33 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Зөрчлийн шинжтэй 412 дуудлага, мэдээллийг өнгөөр нь авч үзвэл бусдын биед халдах-8, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн-27, хулгайлах-5, олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах танхайрах-54, замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын зөрчил 287, хүүхдийн эрх зөрчсөн 10, бусад 3 зөрчил бүртгэгдсэн байна.

Цагдаагийн газрын 102 тусгай дугаарын утсанд иргэн, байгууллагаас ирүүлсэн 585 дуудлага, мэдээллээс 2023 оны эхний хагас жилд /100 хувь/ иргэдтэй холбогдон тэдний санал хүсэлтийг сонсож тэмдэглэл үйлдэж цагдаагийн газрын дарга, удирдлагуудад танилцуулан дуудлага мэдээллийг бүрэн шийдвэрлэсэн эсэхэд хяналт тавьж иргэдэд хариу өгөх ажлыг зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийг мэдээллээр хангах зорилгоор Шуурхай удирдлагын тасгийн самбарыг хүлээлгийн танхимд байршуулж эрэн сурвалжлалт, зарлан мэдээлэл, урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах болон шаардлагатай бусад мэдээллийг долоо хоног бүр шинэчлэн ажилласан.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2023 онд цагдаагийн байгууллагын дотоод сүлжээнд холбогдсон давхардсан тоогоор 11 компьютерт үзлэг хийж, дахин давтагдашгүй MAC хаягаар бүртгэлжүүлж, нууцлалыг шалгаж, процессоруудыг зориулалтын лацаар лацдаж, нийт 11 алба хаагчаас нууцлалын баталгаа авсан.

Байгууллагын дотоод сүлжээний топологи зургийг стандартын дагуу гарган хэлтсийн даргаар батлуулж, алба хаагчдын өрөөний сүлжээний кабель утсыг цэгцэлж, давхардсан тоогоор нийт 14 удаагийн сүлжээ, техник хэрэгслийн гэмтлийг засварласан байна.

Мөн цагдаагийн хэлтсийн алба хаагч нарын аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн хэлтэс руу нэвтрэх үед угтагч цагдаа иргэдийг бүртгэх бүртгэл хөтөлж, дотуур холбоогоор тухайн иргэнтэй уулзах алба хаагчдад мэдэгдэж зөвшөөрөлтэйгээр нэвтрэх, овор ихтэй ачаа тээш, сэжигтэй байдлаар /согтуу, ямар нэг зорилгогүйгээр нэвтрэхээр оролдсон/ биеэ авч яваа иргэдийн бичиг баримтыг /шалган ажиллаж хэвшсэн.

Гомдол мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаанд нь мэдээллийн санд шивж байгаа байдалд өдөр тутам хяналт тавьж ажилласнаар хугацаа хэтэрсэн гомдол мэдээлэл бүртгэгдээгүй.

Мэдээлэл, дүн шинжилгээ шуурхай удирдлагын албаны Цахим мэдээллийн аюулгүй байдлын хэлтэст мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор домайн хаяг нээлгэхээр 11, нууц үг сэргээлгэхээр 9, албан тушаалын нэршил өөрчлүүлэхээр 8 алба хаагчийн хүсэлтийг хүргүүлж, “нууц” албан бичгээр код ирүүлсэнийг 4 алба хаагчид хүлээлгэн өгч ажиллалаа. Мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах, албаны мэдээлэл, нууцлал алдагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагчдын албаны компьютерын нууц үг алдагдсан, нууц үгээ өөрчилсөн эсэх талаар 1 удаа хяналт, шалгалтыг явуулж, компьютерийн нууц үгээ солиогүй 3 алба хаагчийн нууц үгийг солиулж, 5 алба хаагчийн хүсэлтээр нууц үгийг өөрчилж, эдгээр алба хаагчдад мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар биечлэн зөвлөгөө өгч ажиллалаа.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Хэрэглэгчийн хандах эрх ба нууц үгийн удирдлага” код 700.2 /109-ийн хэрэгжилтийг хангуулан, тасаг, хэсгийн дарга 3 алба хаагчид цахим гарын үсгийн и-токен багажийг хүлээлгэн өгч шийдвэрлэсэн.

Шинээр цагдаагийн байгууллагын хэмжээнд нэвтэрсэн Мэдээлэл, дүн шинжилгээ, судалгааны сан /research.police.gov/, Police Sop аппликейшнүүдийг бие бүрэлдэхүүнд танилцуулж хэрхэн ашиглах талаар сургалтыг 1 удаа зохион байгуулсан.

Цагдаагийн хэлтсийн 53 алба хаагчдад Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн “Хэт богино долгионы радио холбоонд ашиглах радио торны нэрийг шинэчлэн батлах тухай” Н-1а/04 дүгээр тушаалыг танилцуулж, сургалт зохион байгууллаа.

Радио торны нэр, дуудлагыг шинэчлэн цагдаагийн хэлтсийн даргаар батлуулж, алба хаагчдыг хэт богино долгионы радио станцаар харилцах, торны нэр, дуудлага, команд, харилцах кодыг зөв хэрэглэж байгаа эсэхийг шалган ажиллалаа.

Сүмбэр сумын 3 баг Нарамдал хотхонд шинээр 7 цэгт PTZ, хайрцаг, свич, уртасгагч, медиа конвертер зэрэг тоног төхөөрөмжийг суурилуулж, цахилгааны холболтыг хийсэн. Нийт 18 цэгт тавигдсан хуучин хяналтын камеруудыг Bullet камераар сольж суурилуулан, свич, медиа конвертер зэрэг холбогдох хэрэгслийг сольсон.

Мөн Сүмбэр сумын 1,2 дугаар багийн нутаг дэвсгэрт ажиллахгүй, засварлуулах, солих шаардлагатай камеруудын судалгааг 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр шинэчлэн гаргаж гудамж талбайд 20, хөдөлгөөнт 8, Hikivision 32ch 4k Deepinmind 2, хард диск 8, медиа конвертор 10, Поё свич 30, дагалдах хэрэгсэлүүдийг засварлуулахаар 50,288,000 төгрөгийн төсвийн саналыг хүргүүлэн 13.303.000 төгрөгийн зардлыг шийдвэрлүүлэн засварын ажлыг хийснээр өнөөдрийн байдлаар нийт 55 хяналтын камер ажиллахаас 54 камер хэвийн ажиллагаатай байна.

Аймгийн хэмжээнд “Ногоон бүс” төслийг хэрэгжүүлэхээр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга гишүүдээс бүрдсэн 13 албан тушаалтан 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Улаанбаатар хотод очиж Чингэлтэй дүүргийн 2 дугаар хэлтсийн камержуулалтын үйл ажиллагаатай биечлэн танилцаж аймгийн хэмжээнд тус төслийг хэрэгжүүлэхээр камерын стандарт, багтаамж, байршил, цэг, төсвийн тооцооллыг хийх чиглэлийн дагуу техник тоног төхөөрөмжийн зардал 700,259,395 төгрөгийн төсвийн тооцоо, Сүмбэр сум 1-р багт “Ногоон бүс” төслийн хүрээнд теле хяналтын камер байршуулах цэгийн судалгааг гаргаж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд албан бичиг хүргүүлж 100.000.000 төгрөгний санхүүжилтийг шийдвэрлүүлж камер тавих тендерийг зарласан.

Зөрчлийн хэрэг бүртгэх албаны чиглэлээр:

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн Б/257 дугаар тушаалаар Зөрчлийн хэрэг бүртгэх газар байгуулагдаж, цагдаагийн хэлтэст шинээр

зөрчлийн хэрэг бүртгэх тасаг байгуулагдаж, тасгийн дарга, зөрчлийн хэрэг бүртгэгч бүрэлдэхүүнтэй 2 алба хаагч томилогдон ажиллаж байна.

Цагдаагийн хэлтэс нь энэ оны эхний хагас жилийн байдлаар нийт 412 зөрчлийн гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 410 буюу 99.5 хувийг шийдвэрлэсэн. Үүнээс зөрчлийн хэрэг нээсэн 174, зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан 22, хялбаршуулсан журмаар шийдсэн 214, одоо 2 гомдлын үлдэгдэлтэй байна. Гомдол мэдээллийн 410 буюу 100 хувь 5 хоногийн хугацаанд шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд 245 зөрчилд торгох шийтгэл оногдуулснаас хуулийн хугацаанд торгуулиа төлөөгүй 10 иргэний торгуулийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар шүүхийн шийдвэрээр албадан гүйцэтгүүлсэн. Алба хаагчдад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журам зөрчихгүй байх чиглэлээр 3 зааварчилга, зөвлөмж өгч, биелэлтэд нь хяналт тавин ажиллалаа.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар 58 хоногоос дээш хугацаанд шалгагдаж байгаа 4 зөрчлийн хэргээс 1 хэргийн эзэн холбогдогчийг олж тогтоон шүүхээр шийдвэрлүүлэн, 1 хэргийг харьяаллын дагуу эрүүгийн цагдаагийн тасагт шилжүүлж, 1 хэрэгт холбогдогчийн сэтгэцэд дүгнэлт гаргуулан хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн. Одоо 1 хэрэг ажиллагаанд шалгагдаж байна. Зөрчил шалгах эрх бүхий алба хаагчдад энэ оны 04 дүгээр сард хэлтсийн даргаас 8 заалт бүхий ажил эрчимжүүлэх үүрэг бичгээр хүргүүлж хэрэгжилтийг тооцон ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар

Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс нь иргэн, хуулийн этгээдээс 585 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 173 буюу 29.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 412 буюу 70.4 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Бүртгэгдсэн гомдол мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүлээн авсан нийт гомдол мэдээлэл 25-аар буюу 4,1 хувиар буурсан.

Энэ оны 06 дугаар сард нийт 76 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 3-аар буюу 3.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хүнд гэмт хэрэг 10 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 5-аар буюу 33,3 буурч хөнгөн гэмт хэрэг 66 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 2-оор буюу 3,1 хувиар өссөн байна. Хэрэг бүртгэлтийн эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 53 хэрэг бүртгэгдсэнээс 32 хэргийн эзэн холбогдогчийг олж тогтоон яллагдагчаар татаж гэмт хэргийн илрүүлэлт 60.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар өссөн дүнтэй байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх /код 227/ журам”, “Дүн шинжилгээ, судалгаа хийх /код 721/ журам”-ыг үндэслэн цагдаагийн хэлтсийн даргын 2023 оны А/01 дугаартай тушаалаар “Дүн шинжилгээ, судалгаа, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх урьдчилан сэргийлэх баг” шинэчлэгдэн байгуулагдаж, байгууллагын 2022 оны криминологи судалгааны тайланд үндэслэн 2023 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан цагдаагийн хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/55 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын 20 заалт бүхий төлөвлөгөө гарган нэгжийн дарга, холбогдох албан тушаалтнуудад хуваарилан өгч, үр дүнг тооцон ажиллалаа.

Дүн шинжилгээ, судалгааны багийн хурлыг 14 хоног тутам хуралдуулж, бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлд 11 удаа дүн шинжилгээ хийж, албан тушаалтнуудад 4 удаа зөвлөмж бичиж, цаашид хийж хэрэгжүүлэх шаардлага ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 2 удаа гарган хэлтэс, тасгуудад хүргүүлж, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч, цагдаагийн хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар 2 удаа

сонсгол танилцуулж ажиллалаа. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Согтуугаар үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчил, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор албан мэдэгдэл 13 бичиж 12 хариуг авч ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Нэгдсэн эмнэлэг, “Энхбилиг” эмнэлэг, Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар, Баянтал сумын Засаг даргын тамгын газар, "Боржигон өв" музей, Боржигин чуулга, Ахмадын хороо, Сүмбэр сумын 5-р сургууль, Шивээговь сумын 3-р сургууль, мөн сумын ГХУСАЗСЗ, Эрүүл мэндийн газар, Политехник коллеж зэрэг нийт 660 иргэнд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Үе тэнгийнхний дээрэлхэлт түүнээс урьдчилан сэргийлэх нь”, “Замын хөдөлгөөний дүрэм”, “Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, шалтгаан нөхцөл”, “Фэйсбүүк орчинд өөрийгөө хамгаалах нь”, “Цахим халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх”, “Электрон тамхины хор уршиг, урьдчилан сэргийлэх”, Эрүүгийн болон зөрчлийн тухай хуулиудын холбогдох заалтууд”, “Хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх нь”, “Авлигын хууль тогтоомж”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж сэдвүүдийн хүрээнд 16 удаагийн сургалтыг зохион байгуулж, 660 иргэнийг хамруулж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс болон бусад алба, нэгжээс зохион байгуулсан Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, хулгайлах, залилах төрлийн гэмт хэрэг, Хүүхдийн эсрэг гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон “Хамтдаа хамгаалъя”, “Нандин бүхнээ хамгаалъя”, “Анзаар”, “Бүү нуугаарай, бүү нуугдаарай”, “Хүн бүр байгаль хамгаалагч” аян, “Бэлэн бай”, “Нэгдье”, “Тэр бум мод”, “Юманд хэмжээ бий” аян зэрэг арга хэмжээнүүдийн хүрээнд ирүүлсэн видео, контентуудыг фейж хуудсандаа байршуулан алба хаагчдаар түгээлгэх ажлыг зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд элсэлтийн ерөнхий шалгалт Сүмбэр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль дээр 2023 оны 06 сарын 15-18-ны өдрүүдэд зохион байгууллагдаж, давхардсан тоогоор 600 суралцагч шалгалтад хамрагдсан байна. Шалгалтын үеэр хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1, багийн цагдаа 1, хүүхэд хамгаалагч 2, school police 4 хүн хүчээр сургуулийн ойр орчимд хяналт тавьж, мэдээлэл солилцож, постер бэлтгэн цахим хуудсандаа байршуулж ажилласан.

“Сар шинэ 2023”, “Илрүүлэлт шийдвэрлэлт”, “Илрүүлэлт шийдвэрлэлт хамтын ажиллагаа”, “Тун шил”, “Нуугдмал”, “Нөхөн сэргээлт”, “Халтиргаа”, “Утаа”, “Уусан бол бүү жолоод”, “Согтуу”, “Мотоцикл” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг цагдаагийн хэлтсийн хэмжээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, цагдаагийн хэлтсээс постер 9, видео зөвлөмж 4, нэвтрүүлэг 1 подкаст 1 бэлтгэн фейж хуудас, байгууллагын цахим хуудсаар сурталчилж, постер 800 ш, зөвлөмж 400 ш тарааж ажилласан.

Цагдаагийн хэлтсээс 2022 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа видео хэлбэрт бэлтгэн байгууллагын фейж болон цахим хуудсандаа байршуулан олон нийтэд хүргэсэн ба Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдын иргэдэд болон Иргэний зөвлөлийн гишүүдэд тайлан танилцуулах арга хэмжээ, Сүмбэр сумын “Нээлттэй хаалганы өдөрлөг”, “Хуульчийн Про боно өдөрлөг”, аймгийн Засаг дарга Сүмбэр, Баянтал, Шивээговь сумд болон Сүмбэр сумын 4,5,6-р багийн иргэдтэй хийх уулзалт, Аймгийн Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын аварга шалгаруулах марш тактикийн тэмцээн, “Цагдаагийн албаны болон дотоодын цэргийн байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх, “Цагдаагийн тангараг” давтах ёслолын арга хэмжээний үеэр иргэдэд байгууллагын үйл ажиллагааг сурталчилж, байгууллагын үйл ажиллагааны тайланг танилцуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 450 иргэнд яриа хийж, зөвлөмж 400 ширхэгийг тарааж, жолооны 2 курстэй хамтран тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтад 17 иргэнийг хөнгөлттэй үнээр бүртгэх ажлыг зохион байгуулсан.

Мөн хүүхэд залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх “Бидний бахархал” төслийг аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 250 хүүхдийг хамруулан зохион байгуулсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус 141 байгууллагуудыг цагдаагийн хэлтсийн 69 алба хаагчдад хариуцуулан хуваарийг 2023.04.25-ны өдөр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргаар батлуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд эхний хагас жилийн байдлаар 16 аж ахуй нэгжийн 450 иргэнд сургалт зохион байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, бусад алба нэгжээс байршуулсан видео, постеруудыг аж ахуй нэгж байгууллагуудын иргэдээр цахим орчинд түгээлгэх ажлыг зохион байгуулж хамтран ажиллаж байна.

Зам тээврийн осол, хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр: “Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын үүрэг оролцоо хамтын ажиллагааг сайжруулах нь” хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулсан ба зөвлөгөөний үр дүнд Босоо тэнхлэгийн арчлалт засвар хариуцсан “Саруул Харгуй” ХХК А0101 дугаартай улсын чанартай авто замд 2023 оны 04 сарын 22-ний өдрөөс 04 сарын 29-ний хооронд нийт 4624 у/м хучилтанд үүссэн ан цавыг компрессороор хогийг үлээлгэж битумээр цутгаж элсээр бэхжүүлж ан цавыг гагнасан, 2023 оны 05 сарын 18-ны өдрөөс 06 сарын 11-ний Далангийн хөрсийг /41,92м3/ сольсон, АБХ-ын 3м2 хүртэлх талбайтай нүхийг халуун асфальтбетоноор /13,56м2/, АБХ-ын 10м2 хүртэлх их талбайтай нүхийг халуун асфальтбетон /31,79м2/, АБХ-ын 10м2-аас их талбайтай нүхийг халуун асфальтбетон /73м2/, хүйтэн асфальтбетон /7,2м3/ хучилтын нийт 74 цэгийн нүхэн эвдрэлийг тус тус засварлаж ажилласан.

Цэцэрлэгийн насны хүүхэд, эцэг эхчүүдэд замын хөдөлгөөнд оролцох зөв дадал олгож хэвшүүлэх, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, хууль дүрмийг сурталчлах зорилгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд "Замын хөдөлгөөний цагаан толгой-2023" тэмцээнийг зохион байгуулж, нийт 7 цэцэрлэгийн 70 хүүхэд, 28 багш, эцэг эхийн төлөөлөл оролцлоо.

Иргэдийг согтуугаар гэмт хэрэг, зөрчилд холбогдох, түүнд өртөж хохирохоос сэргийлэх талаар иргэдийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хууль”-аар 6 байгууллагын 254 ажилтан, алба хаагчдад сургалт зохион байгуулсан.

Согтуугаар үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр аймгийн хэмжээнд хийсэн криминологи судалгааны тайланд үндэслэн “Архидан согтуурахтай тэмцэх дэд хөтөлбөр”-ийг боловсруулсан ба батлуулахаар аймгийн Засаг даргад албан бичгээр хүргүүлээд байна.

Сургуулийн орчинд гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэдэх “Ирээдүйн хөтөч” сайн дурын клуб нь 20 хүүхдийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч, хамтран ажиллаж байна.

ГУРАВ: ДҮГНЭЛТ

Энэ оны эхний хагас жилийн байдлаар гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, алба хаагч, ажилтнуудаас албан үүргээ гүйцэтгэх явцдаа үйлдвэрлэлийн осолд өртөж, хохирсон тохиолдол бүртгэгдээгүй байна.

Прокурорын шаардлага 1-ийг хүлээн авсан нь урд оны мөн үеэс 2-оор буюу 66.6